

APU COMPANY
Absolute. Pure. Unique.



"Эрх зүйчээс фермер болсон нь"

Г.Нямсүрэн

Сүү нийлүүлэгч фермер

Би эрх зүйч мэргэжилтэй ч нөхрийнхөө хамт фермийн аж ахуйг сонгон, ямар ч туршлагагүй эхэлж байлаа. Анхны жилүүд амаргүй байсан ч бид бууж өгөлгүй, суралцаж, хөдөлмөрлөсөөр өнөөдөр 120 гаруй саалийн үнээтэй болсон. Энэ аж ахуй маань бидний хувьд зүгээр нэг ажил биш, амьдралын хэв маяг, чухал нэг хэсэг юм.

2014 оноос АПУ Дэйри-тэй хамтран ажиллаж, сүүгээ тогтвортой нийлүүлэх болсноор орлого маань баталгаажиж, аж ахуй маань илүү тогтвортой хөгжих боломж бүрдсэн. Бид энэ ажлаа сэтгэлээсээ хийж, өдөр бүр сайжруулахыг зорьдог.

АГУУЛГА

УДИРТГАЛ

Бидний тухай	4
ТУЗ-ийн даргын захидал	6
Гүйцэтгэх захирлын захидал	7

АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

Тогтвортой хөгжлийн замнал	9
СТОУС ТБ 1 ба ТБ 2 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажил	10
СТОУС-д нийцсэн үндсэн тодруулга	11

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН 5 ХАНА

Ямалт орших өв соёл	13
Ногоон ба цэвэр тунгалаг	15
Хүчирхэгжсэн хамт олон	18
Баялаг ба хариуцлагатай	21
Тогтвортой тунш	23

ХАВСРАЛТ

Монголын Хөрөнгийн Биржийн БОНЗ-ын үйл ажиллагааны тайлан	28
---	----



УДИРТГАЛ

Бидний тухай
ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал

"Аюулгүй, үр ашигтай тээвэрээр үнэ цэнийг хүргэх нь"

Н.Номин-Эрдэнэ

Тээвэр зохицуулалтын менежер

Би АПУ компанид долоо дахь жилдээ ажиллаж, тээврийн үйл ажиллагааг аюулгүй, тасралтгүй, үр ашигтай зохион байгуулахад анхааран ажиллаж байна. Хүний нөөц, техник хэрэгсэл, зордлыг оновчтой төлөвлөх нь миний ажлын гол зорилго.

2022 оноос хойш бид автомашины парк шинэчлэлтийг үе шалттай хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар 80 хувийг шинэчилсэн. Үүний үр дүнд эвдрэл саатал буурч, жолоочийн ажлын нөхцөл сайжирч, тээврийн бүтээгч бодитоор нэмэгдсэн. Мэргэжлийн, чадварлаг багтайгаа хамтран ажиллах нь миний ажлын хамгийн үнэ цэнтэй хэсэг юм.

УРИА ҮГ



ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

ЭРХЭМ ЗОРИЛГО

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, БҮТЭЭХ
ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ БУЙ БҮХЭНДЭЭ ҮРГЭЛЖ
СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.

АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙД ТАНИГДАХ ЭРХЭМ МОНГОЛ
ХҮМҮҮНИЙ ОЮУН ЧАДВАР, УР УХААН,
ШИНЭЧЛЭЛ, **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН**
УНДАРГА БАЙЯ.

ҮНЭТ ЗҮЙЛС

ТАНИХ
ЭРМЭЛЗЭЛ

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ

Тасралтгүй шинийг эрэлхийлж, суралцаж,
хуваалцаж, туршья.

ҮНЭН
ЧАНАР

ХАМТДАА ЯЛЬЯ

Чанарыг эрхэмлэж, ялалтын
сэтгэлгээгээр урагшлая

БҮТЭЭЛЧ
ЧАДВАР

ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ

Уламжлалаа хүндлэж, шинийг бүтээ

ХҮНЛЭГ
СЭТГЭЛ

ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ

"Хүн" байхыг чухалчилж, сайн сайхныг
түгээ.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Цэвээнжавын **ЭРДЭНЭБИЛЭГ**
Гүйцэтгэх захирал



Жаргалсайханы **ИЧИНХОРЛОО**
Захиргаа, Хүний нөөц
эрхэлсэн захирал



Батсайханы **ЦАЦРАЛ**
Барилуулалт, маркетинг
эрхэлсэн захирал



Гончигийн **ЭНХБИЛЭГ**
Санхүү эрхэлсэн захирал,
Төслийн удирдлагын
захирал



Галсумъяа **БАЯРМАГНАЙ**
АПУ Дэйри
Гүйцэтгэх захирал




АЛЛАН ОНГ
Дижитал шилжилт,
өөрчлөлт эрхэлсэн
захирал



Георгий Губеладзе
Үйлдвэрлэл,
үйл ажиллагаа
эрхэлсэн захирал

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

APU COMPANY
Absolute. Pure. Unique.



Бүтцэд гарсан өөрчлөлт

ТУЗ-ийн 2025 оны 10 сарын 27-ны өдрийн 25/14 тоот тогтоолд үндэслэн АПУ Групп компани 2025 оны 11 сарын 12-ны өдөр “Эс жи пи и” ХХК-ийн 56.68%-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн болно.

■ ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ



АПУ ХК-ийн 2025 оны Тогтвортой хөгжлийн тайланг Та бүхэнд хүргэн мэндчилж байна.

Өнөөдрийн бизнесийн орчинд компанийн үнэлгээ зөвхөн борлуулалт, ашигт ажиллагаагаар хэмжигдэхээ больж, засаглалын чанар, эрсдэлийн удирдлага, байгаль орчин, нийгмийн хариуцлага, урт хугацааны үнэ цэн бүтээх чадамжаар тодорхойлогдох болсон. Иймд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс тогтвортой хөгжлийг АПУ компанийн урт хугацааны стратегийн салшгүй хэсэг гэж үзэн бодлого, хяналт, чиглүүлэлтийн түвшинд тууштай анхаарч ажиллаж байна.

АПУ ХК 2025 онд "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ийн хэрэгжилтийг дараагийн шатанд гаргаж, томоохон төслүүдээ бодит ажил хэрэг болгон урагшлууллаа. Мөн тайланг хугацаанд олон улсын тогтвортой байдлын тайлагналын СТОУС ТБ 1 / ТБ 2 стандартын туршилтад оролцож, тогтвортой байдлын тайлагнал, ил тод байдлаа шинэ шатанд хүргэх суурийг тавилаа. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлцэл, засаглалын чанар, зах зээл дэх өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Дээрх хүчин чармайлт, манлайллыг үнэлэн Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгодог "Шилдэг БонЗ хэрэгжүүлэгч байгууллага 2025" шагналыг хүртсэн нь зөв чиглэл, бодит үр дүнгийн илэрхийлэл хэмээн Төлөөлөн удирдах зөвлөл үзэж байна. ТУЗ-ийн хувьд бид компанийн өсөлтийг зөвхөн өнөөдрийн үр дүнгээр дүгнэх бус, дараагийн зуун жилийг бүтээх стратеги, хөрөнгө оруулалтын сахилга бат, эрсдэлийн удирдлага, хариуцлагатай өсөлтийн тэнцвэрийг хадгалах нь тэргүүлэх зорилт хэвээр байх болно.

АПУ компанийн хөгжилд итгэл хүлээлгэн хамтран ажилладаг нийт хувьцаа эзэмшигчид, түншүүд, ажилтнууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Пүрэвийн Батсайхан

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Batsaikhan

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Бид 2025 онд тогтвортой хөгжлийг үйлдвэрлэл, борлуулалт, нийлүүлэлт, хүний нөөц, хөрөнгө оруулалт, инновацын өдөр тутмын шийдвэр бүрийн нэг хэсэг болгон хэрэгжүүлэхийг зорьж, өсөлт, шинэчлэл, хариуцлагатай хөгжлийг зэрэг урагшлуулсан үр бүтээлтэй жил байлаа.

“Бахархалт Монгол” тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд бид компанийн ирээдүйн өсөлт, бүтээмж, өрсөлдөх чадварыг тодорхойлох таван томоохон төсөл, санаачилгыг бодит ахицтайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэгдүгээрт, АПУ Дэйри компанийн шинэ сүүний үйлдвэрийн төслийг олон улсын ногоон санхүүжилтийн дэмжлэгтэйгээр урагшлуулж, дотоодын сүүний үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал, импортыг орлох чадавхыг нэмэгдүүлэх суурийг тавьсан.

Хоёрдугаарт, АПУ Группийн үйлдвэрүүдийг хамарсан хаягдал ус цэвэрлэх байгууламжийн төслийг эхлүүлж, усыг дахин ашиглах, байгаль орчны нөлөөллийг бууруулах стратегийн хөрөнгө оруулалтыг хийж байна.

Гуравдугаарт, үйлдвэрлэлийн органик дайварыг дахин боловсруулж өндөр шимт малын тэжээлийн түүхий эд болгох төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан бөгөөд 2026 оноос хэрэгжүүлж эхэлснээр хаягдлыг бууруулахын зэрэгцээ тойрог эдийн засгийн бодит шийдлийг бий болгох боломжтой боллоо.

Дөрөвдүгээрт, түгээлтийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх автомат агуулахын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, логистикийн оноочлолоор шатахууны хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Эүүн бүсийн агуулахын төслийг 2026 оноос хэрэгжүүлэх боллоо.

Тавдугаарт, компанийн хамгийн үнэт хөрөнгө болох ХҮН-дээ хөрөнгө оруулж, “InnovTalent”, “Brew the Future”, “Нэг зун – нэг боломж” хөтөлбөрүүдээр дамжуулан ирээдүйн боловсон хүчин, дотоод ур чадварын тогтвортой хөгжлийг цогцоор дэмжин ажиллав.

Дээрх ажлууд нь зөвхөн өнөөдрийн амжилт бус, АПУ Групп компанийн дараа дараагийн жилүүдийн өсөлтийн суурь хөрөнгө оруулалт юм.

2025 оны ололт амжилтын ард зогсож буй нийт ажилтнууд, хэрэглэгчид, харилцагчид, нийлүүлэгчид, түнш байгууллагууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

Цэвэрнжавын Эрдэнэбилэг




2025 ОН Тоогоор

Бууруулсан хүлэмжийн хий
4,370 тн CO2e

(Парк шивсчил болон Eco Mine системийн үр дүнд)

Хэмнэсэн цэвэр ус
18,663 м³

(Дахин ашиглалтын үр дүнд 119.6 сая төгрөг хэмнэсэн)

Усны дахин ашиглалтын хувь
22%

Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалт
50.16%

(Нийт 74,408.27 тонн хаягдлыг эргэлтэд оруулсан)

Цахилгаан эрчим хүчний хэмнэлт
251.828 МВт.ц

Дулааны эрчим хүчний хэмнэлт
3,304 Гкал

(30.7 сая төгрөг хэмнэсэн)

Тарьсан мод
1,300 ширхэг

(Налайв, Төгрөг, СХД-ийн байршлуудад)

Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалт
13.1 цаг

(АПУ Дэйри ХХК-ийн хувьд 13.6 цаг)

Хүний нөөцийн эргэц
18.6%

(Хүний нөөцийн үргэлжлэл)

INNOV TALENT Innov-Talent тэтгэлэг
100 оюутан

BREW THE FUTURE Brew the Future дотоод тэтгэлэг
25 ажилтан

Нутагшуулсан өндөр ашиг шимт үнээ
400

хоньтойн үүлдрийн үнээ



8,478

Эрүүл мэндийн туслалж, зөвлөгөө авсан ажилтанд

Уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн чиглэлээр сургалтад хамрагдсан малчид

158

Шингэн сүүний гарц нэмэгдүүлсэн байдал
Өдөрт 10 тонн

Нийт ажилтнуудын хүйсийн харьцаа:

37.1%

62.9%

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хувь
2.54%




Эргэлтийн шил татан авалт
30%



Дотоодын худалдан авалтын хувь
38.5%

АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

Тогтвортой хөгжлийн замнал
СТОУС ТБ 1 ба ТБ 2 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажил
СТОУС-д нийцсэн үндсэн тодруулга



“Инновац, судалгаанд суурилсан шийдлээр
үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх нь”

Б.Алтанбэхи
Портфолио төслийн менежер

Би 2020 оноос АПУ ХК-д ажиллаж байгаа бөгөөд манай Инновац, судалгаа, хөгжүүлэлтийн алба нь шар айргийн категорийн бүтээгдэхүүний хөгжлийг анхны санаанаас эхлэн хэрэглэгчид хүрэх хүртэл удирдан ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд бид үйлдвэрлэлийн үр ашиг, ханган нийлүүлэлтийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Энэ хүрээнд олон төрлийн шилний дизайныг цөөлж, стандарт савлагаанд шилжсэн. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн шугамын тохиргоонд зарцуулах хугацаа 1-2 цагаар буурч, бүтээмж нэмэгдсэн. Мөн нэг төрлийн шил ашиглах нь нийлүүлэлт, нөөц, төлөвлөлтийг илүү оновчтой болгож, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАМНАЛ



2022

ЭХЛЭЛ биш ҮРГЭЛЖЛЭЛ

Бид 2011 оноос хойш олон улсын ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь байгууллагын үйл ажиллагааг тогтвортой байдлын зарчимд нийцүүлэн, байгаль орчны нөлөөллийг системтэйгээр тодорхойлох, хянах, тасралтгүй сайжруулах суурийг бий болгосон юм. Ингээд 2022 онд бид тогтвортой хөгжлийн суурь тогтолцоогоо олон улсын жишигт нийцүүлж, "Цагаан хувьсгал" хөдөлгөөнийг түүчээлсэн юм.

- **Засаглал:** СЗХ-ноос шинэчлэн баталсан Компанийн засаглалын кодексийг нэвтрүүлж эхэлснээр засаглалын хэрэгжилт 94%-д хүрч, "Засаглал хэвийн, эрсдэлгүй" түвшинд үнэлэгдэв.
- **Цагаан хувьсгал:** Сүүний салбарт нэмүү өртгийн сүлжээг шинэчлэх, малчдын амьжиргааг дэмжих 8 уриалгыг дэвшүүлж, "Монгол сарлаг" – Гэр үйлдвэрлэлийн төслийг Архангай аймагт эхлүүлэв.
- **Нөлөөллийн аянууд:** Хариуцлагатай хэрэглээг сурталчлах "Гайхамшигт жолооч" аяныг анхлан нэвтрүүлж, "Чи чадна – Шилээ дахин амьдруулья" төслөөр шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлэв.
- **Ногоон шийдэл:** "Тайгер" шар айргийн үйлдвэрт хийн болон дизель хосолсон уурын зуух ашиглалтад оруулснаар түүхий нүүрсний хэрэглээг жилд 3000 тонн-оор бууруулах боломж бүрдлээ.

2023

СТРАТЕГИЙН СУУРЬ БА ХҮН ТӨВТЭЙ БОДЛОГО

Түүхт 100 жилийн ойн босгон дээр бид алсын хараагаа шинэчилж, тогтвортой хөгжлийн стратеги боловсруулах шийдвэр гаргав.

- **Алсын хараа ба Уриа:** "Үргэлж Өөдөө" уриатайгаар алсын хараа, эрхэм зорилгоо шинэчлэн тодорхойлж, "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн 2030 стратегийн 5 ханат нөлөөллийн гэр моделийг боловсруулах ажлын ажлууд хийгдэж эхлэв.
- **Хүн төвтэй засаглал:** ТУЗ-өөс ажилтнуудад хувицаа эзэмшүүлэх хөтөлбөрийг (ESOP) 2023.12.05-ны өдөр баталж, ажилтан бүр "эзний ёсоор" хамтын үнэ цэнийг бүтээх суурийг тавив.
- **Бүтээн байгуулалт:** "West-Hub" баруун бүсийн агуулахыг ашиглалтад оруулснаар тээвэрлэлтийн хугацааг 69% хэмнэж, СББ ХХК-ийн 50 жилийн ойгоор Монголдоо хамгийн томд тооцогдох бяслагны үйлдвэрийг нээлээ.
- **Түншлэлийн манлайлал:** Монголын Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) Холбооны дэргэдэж "БоНЗ-ын мэргэжлийн зөвлөл"-д санхүүгийн бус салбарыг төлөөлөн нэгдэв.

2024

СТРАТЕГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ БА НОГООН САНХҮҮЖИЛТ

Бид стратегийн томоохон зорилтуудаа бодит бүтээн байгуулалт болгож, байгаль орчинд ээлтэй дэд бүтцэд хөрөнгө оруулж эхлэв.

- **Стратегийн батламж:** "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ийг Төлөөлөн Удирдах Зөвлөл 2024.07.23-ны өдөр албан ёсоор батлав.
- **Ялгарлын тооллого:** Групп компанийн хэмжээнд Хамрах хүрээ 1, 2, 3 ялгарлын иж бүрэн тооллогыг анх удаа гүйцэтгэж, нийт ялгарал 404,693.39 тн CO2e байгааг баталгаажуулсан.
- **Стандартын аудит:** Олон улсын SGS компаниар ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцооны аудит хийлгэж, гэрчилгээгээ гардан авав.
- **Ногоон санхүүжилт:** Сүүний салбарт ногоон үйлдвэрлэлийг эрчимжүүлэхээр 40 сая долларын хамтын санхүүжилтийн гэрээг АХБ болон ЕСБХБ-тай байгууллаа.

2025

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ БА ШИЛДЭГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

АПУ ХК тогтвортой байдлын тайлагналаа олон улсын түвшинд хүргэх эхлэл тавьж, тогтвортой хөгжлийн томоохон хөрөнгө оруулалтыг хийсэн жил байлаа.

- **WWTP төсөл:** 45 тэрбум төгрөгийн өртөгтэй Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн шавыг 2025.06.10-нд тавьж, бүтээн байгуулалтыг эхлүүлэв.
- **СТОУС-ын туршилт:** Олон улсын тогтвортой байдлын тодруулгын стандартыг (IFRS S1, S2) техникийн түвшинд туршив.
- **Шагнал урамшуулал:** Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос "Шилдэг БоНЗ хэрэгжүүлэгч байгууллага 2025" хүндтэй шагналыг хүртлээ.
- **Сүүний салбарын инноваци:** Дэлхийн тэргүүлэгч Yli Group-тэй хамтран Холштейн үүлдрийн 400 хээлтэй үнээг нутагшуулж, "Superior Taste Award 2025" шагналыг сүүн бүтээгдэхүүнүүдээрээ хүртэв.
- **Тойрог эдийн засаг:** Органик хаягдлаас малын тэжээлийн түүхий эд үйлдвэрлэх (DDGS) 25 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

СТОУС ТБ 1 БА ТБ 2 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖИЛ

АПУ ХК нь 2025 онд Монгол Улсын Сангийн яам болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-тэй хамтран Олон улсын тогтвортой байдлын тодруулгын стандартууд болох СТОУС ТБ 1 (IFRS S1) болон СТОУС ТБ 2 (IFRS S2) стандартыг турших пилот төсөлд хамрагдлаа.

Энэхүү төсөл нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн тогтвортой байдлын тайлагналын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн байгууллагуудад хүргэх мэдээллийн чанар, ил тод байдлыг сайжруулах зорилготой юм.

СТОУС ТБ 1 стандарт нь тогтвортой байдалтай холбоотой санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлагыг тогтоодог бол СТОУС ТБ 2 стандарт нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломж, стратеги, хэмжүүр болон зорилтуудын тодруулгад чиглэдэг.

АПУ ХК энэхүү туршилтын хүрээнд дотоод ажлын хэсэг байгуулж, засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, мэдээллийн өгөгдөл, тайлагналын үйл явцын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн, цаашид шаардлагатай хөгжүүлэх чиглэлүүдээ тодорхойлсон.

Мөн тус пилот төслийн үр дүн, оролцогч байгууллагуудын туршлага, санал, зөвлөмжид үндэслэн Монгол Улсад Тогтвортой байдлын тодруулгын стандартыг үе шатайгаар нэвтрүүлэх замын зураг буюу Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг 2026-2032 онд нэвтрүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулагдсан нь энэхүү ажлын нэг чухал үр дүн байлаа. АПУ ХК нь тус бэлтгэл ажилд оролцсоноор хувийн хэвшлийн байгууллагын туршлага, хэрэгцээ шаардлагыг тусгахад хувь нэмрээ оруулав.

Цаашид АПУ ХК нь тогтвортой байдлын тайлагналын олон улсын шаардлагыг үе шатайгаар нэвтрүүлж, мэдээллийн чанар, өгөгдлийн нэгдсэн тогтолцоо, эрсдэлийн удирдлага, ил тод байдлыг тасралтгүй сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

Мөн СТОУС ТБ 1 болон ТБ 2 стандартын шаардлагад аажмаар нийцүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлж, Монгол Улсад тогтвортой байдлын тайлагналын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.



СТОУС-Д НИЙЦСЭН ҮНДСЭН ТОДРУУЛГА

АПУ ХК нь Олон улсын тогтвортой байдлын тодруулгын стандартууд болох СТОУС ТБ 1 болон ТБ 2 стандартын хүрээнд тогтвортой байдлын мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн тайлагнах бэлтгэл ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү стандартын дагуу мэдээллийг Засаглал, Стратеги, Эрсдэлийн удирдлага, Тоон үзүүлэлт ба зорилтууд гэсэн дөрвөн үндсэн бүлгээр тодруулдаг.

ЗАСАГЛАЛ

АПУ ХК-ийн ТУЗ нь компанийн урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтөд нөлөөлөх байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудад улирал бүр хяналт тавин ажилладаг.

Гүйцэтгэх захирал болон удирдлагын баг нь стратегийн хэрэгжилт, хэрэгжилтийн гүйцэтгэлийг тухай бүр хянан ажилладаг.

2025 онд СТОУС ТБ 1 ба ТБ 2 стандартыг турших зорилгоор санхүү, тогтвортой хөгжил, эрсдэл гэсэн чиг үүргийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж ажиллав. Тус ажлын хэсэг нь мэдээллийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай өгөгдлийн эх үүсвэрүүдийг тодорхойлох, туршилтаар тайлагналыг бэлтгэж ажилласан.

Цаашид тогтвортой байдлын асуудлыг дээрх стандартуудад бүрэн нийцүүлэх, удирдлагын түвшний шийдвэр гаргалттай илүү нягт уялдуулж, засаглалын бүтэц, хяналтын тогтолцоог шат дараатай бэхжүүлэхээр зорьж ажиллах болно.

СТРАТЕГИ

АПУ ХК нь тогтвортой хөгжлийг бизнесийн урт хугацааны стратегийн нэг хэсэг болгон авч үзэж, "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратеги 2030-аа ТУЗ-ийн хэмжээнд батлан, хэрэгжүүлж байгаа билээ.

Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол, хэрэглэгчийн хүлээлтийн өөрчлөлт, санхүүгийн зах зээлийн шинэ шаардлагууд нь компанийн бизнесийн орчинд нөлөөлж буй тул стратегийн түвшинд дараах чиглэлүүдэд анхаарч байна. Үүнд:

- Усны хэрэглээ болон хаягдал усны менежмент
- Эрчим хүчний үр ашиг, ялгарлын бууралт
- Сав баглаа боодол, тойрог эдийн засгийн шийдлүүд
- Дотоодын түүхий эд, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал
- Бүтээгдэхүүний шинэчлэл
- Ногоон болон тогтвортой санхүүжилтийн боломжууд



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АПУ ХК нь тогтвортой байдалтай холбоотой эрсдэл, боломжуудыг компанийн нийт эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үе шаттайгаар нэгтгэн ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд 2025 онд СТОУС-ын туршигтын ажлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой дараах эрсдэлүүдийг чанарын түвшинд тодорхойлж эхэллээ.

Биет эрсдэлүүд:

- Усны хомсдол, усны хүртээмжийн өөрчлөлт
- Үер, хур тунадас, цаг агаарын эрс тэс нөхцөл
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн нийлүүлэлтэд үзүүлэх нөлөө

Шилжилтийн эрсдэлүүд:

- Байгаль орчны зохицуулалтын шаардлагын өсөлт
- Эрчим хүч, түүхий эдийн үнийн хэлбэлзэл
- Хэрэглэгчдийн сонголтын өөрчлөлт
- Тайлагнал, ил тод байдлын шаардлага нэмэгдэх

Цаашид эдгээр эрсдэлийг тоон түвшинд үнэлэх, бизнес төлөвлөлтөд тусгах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэх болно.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ БА ЗОРИЛТУУД

АПУ ХК нь тогтвортой хөгжлийн гүйцэтгэлийг хэмжих зорилгоор үйл ажиллагааны болон ESG буюу Байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлийн үндсэн үзүүлэлтүүдийг хөгжүүлж байна.

2025 онд компанийн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд стратегийн 5 багана тус бүрээр ажлууд төлөвлөсөн буюу нийт 48 ажил төлөвлөсний хэрэгжилтийн түвшин Төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжсэн ажлын гүйцэтгэл 93% хүрсэн нь төлөвлөлт, нийлүүлэлт, гүйцэтгэлийн сахилга батыг илэрхийлж байна.

Мөн салбарын онцлогт нийцсэн дараах үзүүлэлтүүдэд анхаарч ажиллав. Үүнд:

- Усны хэрэглээний үр ашиг
- Лонх дахин ашиглалт
- Хүлэмжийн хийн ялгарлын суурь өгөгдөл бүрдүүлэлт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал
- Ажилтны сургалт, хөгжил
- Хариуцлагатай хэрэглээний хөтөлбөрийн хамрах хүрээ

Цаашид АПУ ХК нь өгөгдлийн чанар, нэгдсэн систем, хэнжилтийн аргачлалаа сайжруулж, зорилтот түвшинд суурилсан илүү нарийвчилсан үзүүлэлтүүдийг тогтмол тайлагнах зорилт тавин ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН 5 БАГАНЫН ГҮЙЦЭТГЭЛ

Ямагт орших өв соёл

Ногоон ба цэвэр тунгалаг

Хүчирхэгжсэн хамт олон

Баялаг ба хариуцлагатай

Тогтвортой түнш



"Саарал усны шийдлээр нөөцөө хэмнэх нь"
Ц.Батсүх, Усны инженер

Би 1987 оноос хойш АПУ компанид тасралтгүй 39 гаруй жил ажиллаж, дулаан, сантехник, усны инженерийн чиглэлээр олон төсөл хэрэгжүүлсэн. Миний мэргэжлийн бахархал бол шинэ техник, технологийг анхлан нэвтрүүлж, үйлдвэрлэлд бодитоор хэрэгжүүлэх явдал юм.

2016 оноос саарал ус ашиглах судалгааг эхлүүлж, өнөөдөр компанийн хэмжээнд 6 автомат системийг амжилттай ажиллуулж байна. Саарал усыг үйлдвэрлэл, цэвэрлэгээ, ногоон байгууламжийн усалгаа зэрэгт ашигласнаар усны хэрэглээг бууруулж, байгальд үзүүлэх нөлөөллийг багасгаж байна.



Зорилго:

Монгол үндэстний гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АПУ ХК өөрийн бизнесийн практик, хамтын ажиллагаа, нөөц боломжоо бүрэн ашиглах болно.

ҮНДЭСНИЙ СОЁЛ БА БАХАРХАЛТ ӨВ

Үндэсний өв соёлоо дээдлэн, хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх "Ямагт орших өв соёл" стратегийн баганын хүрээнд бид Эрийн гурван наадмын төрлүүд болон шагайн харвааг бодлогоор дэмжин ажиллаж байна.

- **Морин спорт:** Сэнгүр брэндээр дамжуулан "Их хурд-10" үндэсний морины уралдааныг ивээн тэтгэв.
- **Шагайн харваа:** АПУ ХК-ийн шагайн харвааны баг 2025 онд амжилт арвинтай байж, Даншиг наадамд дэд байр, "Ерөнхийлөгчийн нэрэмжит шилжин явах цом"-ын аваргаар шалгарлаа.
- **Үндэсний бөхийн спорт:** "Алтан цом 2025" барилдаанд "АПУ-Скайтел" баг хамтран оролцлоо.
- **"Соёлоор гоёно"** контент: Үндэсний уламжлал болсон дээрх спортын төрлүүдийг залуу үедээ таниулах, тэдний бахархлыг төрүүлэх зорилготой "Соёлоор гоёно" цуврал видео контентуудыг системтэйгээр бэлтгэн хүргэж байна.



Эдгээр ажлууд нь компанийн "Бахархалт Монгол" стратегийн хүрээнд монгол хүний оюун чадвар, өв уламжлалыг дэлхийн тавцанд гаргах, дотооддоо нүүдэлчин ахуйн үнэт зүйлсийг хамгаалан үлдэх зорилготой шууд уялдаж байгаа юм.



АПУ КОМПАНИЙН ТАМИРЧИД:

Үндэсний бөхийн спорт:



МУ-ын Арслан
Б.Орхонбаяр



МУ-ын Харцага
Т.Өсөх-Ирээдүй



МУ-ын Харцага
Б.Цэдэнсодном



МУ-ын Заан
Т.Санчир



Аймгийн Хурц Арслан
Н.Амгаланбаатар



Аймгийн Арслан
Ч.Даваасүрэн



Аймгийн Арслан
С.Доржпалан

Нум сум харваа:



МУ-ын Даян мэргэн
Б.Пунсалдулам



МУ-ын Тод мэргэн харваан
Б.Зоригтбаатар



МУ-ын Тод манлай уяач
О.Батбилэг

Шагайн харваа:



МУ-ын Үлэмж, Дархан мэргэн
С.Ямааран



МУ-ын Дархан мэргэн
Б.Гончигзав



МУ-ын Гарамгай мэргэн
Г.Дорждаваа



МУ-ын Дархан мэргэн
Ц.Пүрэв

СҮҮНИЙ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ШИНЭ ТҮНШЛЭЛ

Монголын өв соёл, уламжлалт үнэ цэнийг орчин үеийн бизнесийн хөгжилтэй хослуулан хадгалж, ирээдүй үед өвлүүлэх зорилгоор АГУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хаан банк, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо болон Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран сүүний салбарын тогтвортой хөгжлийн цогц түншлэлийг эхлүүлээ.



Энэхүү санаачилгын хүрээнд дэлхийн тэргүүлэх Yili Group-тэй хамтран өндөр ашиг шимтэй Холштейн үүлдрийн 400 хээлтэй үнээг Монгол Улсад нутагшуулж, сүүний фермерүүдэд орчин үеийн менежмент, тэжээл, үржүүлэг, мал эмнэлэг, технологийн шийдлүүдийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв. Үр дүнд нь шингэн сүүний үйлдвэрлэлийн хэмжээг өдөрт 10 тонноор нэмэгдүүлэв.



Төслийн нөлөөгөөр сүү нийлүүлэгч малчид, фермерүүдийн орлого 25-30 хувиар өсөх боломжтой бөгөөд дотоодын сүүний нийлүүлэлт нэмэгдэж, орон нутагт ажлын байр бий болох, сүүний салбарын үнэ цэнийн сүлжээ шинэ шатанд гарах суурь бүрдэж байна.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ БА МАЛЧДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Малчдын нийгмийн болон эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх нь манай нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын үндэс юм.

Эрүүл малчин: Бид сүү бэлтгэлийн сүлжээний тогтвортой байдлыг хангах зорилгоор 8 дугаар сард "Эрүүл малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд сүү бэлтгэлийн сүлжээний нийт 346 малчныг бүтэн биеийн оношилгоо, эрүүл мэндийн их бүрэн үзлэгт хамрууллаа. Малчдын бие махбодын эрүүл мэндэд анхаарахаас гадна тэдний өдөр тутмын хөдөлмөрийг хөнгөвчлөх, амьдралын чанарыг нь сайжруулах замаар салбарын тогтвортой хөгжлийг дэмжиж байна.



Малчдын нийгмийн болон эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх нь манай нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлын үндэс юм.

Эрүүл малчин: Бид сүү бэлтгэлийн сүлжээний тогтвортой байдлыг хангах зорилгоор 8 дугаар сард "Эрүүл малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд сүү бэлтгэлийн сүлжээний нийт 346 малчныг бүтэн биеийн оношилгоо, эрүүл мэндийн их бүрэн үзлэгт хамрууллаа. Малчдын бие махбодын эрүүл мэндэд анхаарахаас гадна тэдний өдөр тутмын хөдөлмөрийг хөнгөвчлөх, амьдралын чанарыг нь сайжруулах замаар салбарын тогтвортой хөгжлийг дэмжиж байна.



Чадваржуулах сургалт: НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD)-тай хамтран 5 болон 11 дүгээр сард "Фермерүүдэд тэжээл бэлтгэл, тэжээлийн баланс тохируулга" сэдэвт 6 модуль бүхий сургалтыг зохион байгууллаа.

ОРОЛЦОГЧИД
фермер **158** ⁴¹/₁₁₇ хот орчмын бүс
Зүүнхараа сумаас

ЖЕНДЭРИЙН
оролцоо **71**  "Эрхэт" эмэгтэйнүүдийн сүүний хоршооны
тишүүд онцлох үүрэгтэй оролцов.

• **Үр дүн:** Фермерүүд тэжээлийн оновчтой менежмент, малын эрүүл мэндийг сайжруулах, сүүний чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдлэг, ур чадвараа ахиулсан

Туршлага судлах хөтөлбөр: Сүүний гарц, ашиг шимээрээ дэлхийд тэргүүлэгч орнуудын туршлагаас суралцах зорилгоор 30 харилцагч фермерийг БНХАУ-д туршлага судлах аялалд хамрууллаа.

- Судлах чиглэл: Фермийн менежмент, орчин үеийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үхэр маллагааны шилдэг аргуудыг газар дээр нь танилцуулсан.
- Ан холбогдол: Энэхүү хөтөлбөр нь Монголын сүүний салбарыг олон улсын жишээт ойртуулж, фермерийн аж ахуйг илүү үр ашигтай, тогтвортой болгоход чиглэж байна.



Цахим шинжилгээ: Бид мал аж ахуйн салбарт дижитал шийдлийг нэвтрүүлж, үйл ажиллагааг ил тод, хяналттай болголоо.

- "Agribagsh" апп: 11 дүгээр сард нэвтрүүлсэн тус аппликейшн нь малын хооллолт, эрүүл мэнд, сүүний эдийн засгийн мэдээллийг аудио, видео, бичвэр хэлбэрээр нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн. Мөн малын жинд тохирсон тэжээлийн харьцааг тооцоолох функцээр хангагдсан.
- MRV систем: Сүүний нийлүүлэгчдээс (сүүний гарц, чанар, үнээний тоо, хүлэмжийн хийн ялгарал зэрэг) мэдээлэл цутгуулж, дүн шинжилгээ хийх зорилгоор Хяналт, тайлагнал, баталгаажуулалтын (MRV) системийг нэвтрүүлж, 500 гаруй нийлүүлэгчийг хамруулан хянаж эхлээд байна.



Эдийн засгийн дэмжлэг: Архангай аймгийн Чулуут суманд хэрэгжүүлж буй сарлагийн сүүний "МонТяк" брэндийн хүрээнд малчдын амьжиргааг бодитоор дэмжиж байна.



Зорилго:

Эх дэлхий, байгаль орчинд үлдээж буй ул мөрөө багасгахын тулд сэтгэлгээний хэвшмэл хязгаарыг давж, сэтгэл зүтгэл гарган, өвөг дээдсийнхээ хадгалан үлдээсэн байгаль экологийн тэнцвэрийг идэвхтэй хамгаална.

ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ

2025 оны 6-р сарын 10-ны өдөр АПУ ХК нь Үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн төслийн шав тавьлаа. Уг төслийн хүрээнд компанийн үндсэн үйлдвэрүүд болох Төв АПУ үйлдвэр, АПУ Дэйри ХХК, Натур Агро спиртийн үйлдвэр, М-Би-Си Азия Пасифик ХХК-ийн хаягдал усыг дахин боловсруулан ашиглах олон улсын жишигт нийцсэн цэвэрлэх байгууламжийг байгуулж байна. Уг төсөл нь нийтдээ 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий хоногт 2800 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай, MNS 6561:2024 (Хаягдал усны технологи), MNS 6734:2018 (Дахин ашиглах цэвэрлэсэн усны стандарт) гэсэн стандартуудыг хангана.

Тус төсөл хэрэгжсэнээрээ Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг бууруулах, Туул голын усны чанарыг хамгаалах, улмаар байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалахад нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаагаараа давуу талтай.



ОРГАНИК ХАЯГДЛААС МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ТҮҮХИЙ ЭД ҮЙЛДВЭРЛЭХ

Спирт болон шар айргийн үйлдвэрлэлээс үүсэх органик дайвар хаягдал (шаар, хөрөнгө)-ыг дахин боловсруулж, өндөр шимт малын тэжээлийн түүхий эд үйлдвэрлэх 25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий үйлдвэрийн төслийн судалгааг дуусгаж, 2026 онд хэрэгжүүлэн, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Уг төслийн хүрээнд органик дайварыг дахин ашигласнаар нүүрсхүчлийн хийн ялгарлыг 40-50%, метан хийн ялгарлыг 90-100% бууруулах боломж бүрдэнэ. Ийнхүү үйлдвэрлэлийн процессоос үүсэж буй органик хаягдлыг дахин боловсруулан ашигласнаар АПУ компанийн үйлдвэрлэлийг тойрог эдийн засагт хөтлөх үр дүнтэй юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮЛЭМЖИЙН ХИЙН МЕНЕЖМЕНТ

АПУ ХК нь 2024 онд групп компанийн хэмжээнд анх удаа Хамрах хүрээ 1, 2, 3 ангиллаар хүлэмжийн хийн ялгарлын иж бүрэн тооллогыг олон улсын аргачлалын дагуу хийж, суурь түвшнээ тогтоосон.

2025 оны тайлант жилийн хүлэмжийн хийн тооллогын ажил одоогоор үргэлжилж байгаа бөгөөд 2024 онд ашигласан аргачлал, хамрах хүрээ, өгөгдлийн чанарын зарчимд тулгуурлан шинэчлэн тооцоолж байна. Тооллогыг бүрэн дууссаны дараа компанийн албан ёсны сувгаар олон нийтэд тусад нь мэдээлэх болно.

Мөн бид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит алхам хийж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр тээврийн хэрэгслийн парк шинэчлэл болон технологийн сайжруулалтын үр дүнд 2025 онд нийт 4,370 тн CO2e ялгарлыг бууруулж чадлаа.



Тээврийн парк шинэчлэл: Тээврийн хэрэгслийн дундаж насжилтыг 15 байсныг үе шаттайгаар 8 жил болгон бууруулсан. Тайлант онд нийт 33 автомашиныг 0 км гүйлттэй шинэ техникээр сольж, 10-аас дээш насжилттай 23 автомашинд "Eco Mine" утаа бууруулах систем суурилуулснаар утаа ялгарлыг 50%-иар бууруулсан.

Цахилгаан техник: Одоогийн байдлаар 2 ширхэг BYD T3 цахилгаан автомашин, агуулахын үйл ажиллагаанд 47 цахилгаан сэрээт анигчийг ашиглан түлшний хангаарлыг багасгаж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

АПУ ХК нь 2025 онд эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний баг байгуулж, үйлдвэрийн нэгжүүдэд улирал тутам уур, ус, дулаан, цахилгааны хэрэглээ болон алдагдлын аудит хийж хэрэгжүүлэв. Аудитын үр дүнд илэрсэн үл тохирлуудыг засварлан, энергийн алдагдлыг бууруулах, мөн олон улсын сайн туршлагад тулгуурласан хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлээ. Үүний хүрээнд өндөр хэрэглээтэй тоног төхөөрөмж, нэгжүүдийн ашиглалтыг оновчтой болгох шийдлүүдийг үе шаттай нэвтрүүлсэн.

Цахилгаан эрчим хүчний хэмнэлт: 2025 онд Төв АПУ сайтын хэмжээнд гэрэлтүүлгүүдийг LED-ээр сольж, компрессорын даралтыг оновчилсноор нийт **251.828 МВт.ц** цахилгаан хэмнэв.

Дулааны эрчим хүч ба хаягдал дулаан: Группийн хэмжээнд **3,304 Гкал** дулааны эрчим хүч хэмнэж, **30.7 сая** төгрөгийн зардал хэмнэсэн байна. Тухайлбал, хийн компрессороос ялгарах халуун агаарыг савлах хэсгийг халаахад ашиглах шийдлийг нэвтрүүлсэн.

Эүүнхараа дахь үйлдвэрийн уурын зуухны янданд фильтр суурилуулсанаар хүлэмжийн хийн ялгарлыг шууд бууруулах үр дүнтэй ажил болов.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

Бид 2011 оноос хойш олон улсын ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь байгууллагын үйл ажиллагааг тогтвортой байдлын зарчимд нийцүүлэн, байгаль орчны нөлөөллийг системтэйгээр тодорхойлох, хянах, тасралтгүй сайжруулах боломжийг бүрдүүлж байна. Энэхүү тогтолцоо нь "Бахархалт Монгол" стратегийн гол тулгуур болох байгаль орчны хариуцлага, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих бодлоготой уялдан хэрэгжиж байна.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын менежмент нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжихэд чухал тул АПУ ХК нь энэ чиглэлд системтэй арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Ангилан ялгалт: Үйлдвэр болон оффист хог хаягдлыг дахивар, цаас, ахуйн, аюултай гэсэн 4 төрөлд ангилан ялгаж байна.

Дахин ашиглалт: Органик хаягдлыг малын тэжээлд ашиглуулах зорилгоор Баялаг Фийд ХХК-д нийлүүлж, гялгар уутыг Мультипак ХХК-д дахин боловсруулж байна.

Тээвэрлэлт, дахин боловсруулалт: Ахуйн хог хаягдлыг Эко Орчин ХХК тээвэрлэн дахин боловсруулах болон дахин ашиглах байгууллагуудад нийлүүлж, дахин боловсруулах боломжгүй хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэдэг.

Аюултай хог хаягдал: Аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй Түмэн элшиг ХХК, Элемент медикал ХХК компаниудтай хамтардаг бөгөөд 2025 оноос эхлэн Электрокем компанид хаягдал аккумулятор нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Нийгмийн оролцоо: 2024 оноос Өнгө нэм ТББ-ын "Дахин боловсруулцагч - Go Recycle" аянд Ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажиллаж, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг дэмжиж ажиллалаа.

ШИЛ ТАТАН АВАЛТ

АПУ компани нь 18 аймгийн 650-700 харилцагчаас лонхыг гадаад болон дотоод сувгаар эргүүлэн татаж, эргэлтийн системийг хэрэгжүүлж байна. Манай Төв АПУ үйлдвэр дээрх эргэлтийн лонх угаах үйлдвэр нь жилд **12-15 сая**, АПУ-Зүүнхараа үйлдвэр жилд **2.5-3 сая**, АПУ-Амгалан үйлдвэр **35 сая лонх** угаах хүчин чадалтай, брэндийн лонхыг угаан дахин ашиглалтанд бэлтгэдэг.

2025 онд эргэлтээр дахин ашиглагддаг лонхтой бүтээгдэхүүний нийт борлуулалтын дүнтэй харьцуулахад 30 хувийг эргүүлэн татаж, дахин ашигласан үзүүлэлттэй байна. Бид сав, баглаа боодлын эргэлтийн тогтолцоог сайжруулах, шинэчлэгдсэн савлагаанд нийцсэн татан авалтын үйл ажиллагааг тогтворжуулах замаар дахин ашиглалтын хувийг 2030 он хүртэл эргэлтийн шил татан авалтын түвшнийг 58%-д хүргэх зорилттойгоор ажиллаж байна.



"Эргэлтийн сав баглаагаар нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх нь"

О.Амарзаяа

Эргэлтийн сав баглаа боодол хариуцсан аналит.

Би 2022 оноос хойш эргэлтийн сав, баглаа боодол хариуцсан аналитаар ажиллаж байна. Миний ажил богино болон урт хугацааны татан авалтын төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, процессын сайжруулалт болон идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Мөн татан авалтын сувгууд болон бэлтгэн нийлүүлэгчидтэй нягт хамтран ажиллаж, гэрээний нөхцөлийг оновчтой болгох замаар нийлүүлэлтийн уялдаа холбоог сайжруулж байна. Ингэснээр эргэлтийн сав баглаа боодлын ашиглалт нэмэгдэж, нөөцийн үр ашг болон үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

АПУ ХК нь байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих хүрээнд 2025 онд мод тарих, гол усны эх хамгаалах, гол орчмын цэвэрлэгээний ажлуудаа уламжлал болгон хэрэгжүүлэв.

Мод тарилт: Тайлант хугацаанд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Баянзүрх дүүргийн Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн болон Сонгинохайрхан дүүргийн Иннон мөрөөдлийн төгөл зэрэг байршлуудад нийт 1,300 мод (улиас, хайлаас, нарс) тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэв.



Тунгалаг Туул гол орчныг цэвэрлэх өдөрлөг: Ажилтнууд болон ИнновТалент тэтгэлэгт хөтөлбөрийн оюутнуудын оролцотойгоор Туул голын ай савын тодорхой бүсийг цэвэрлэн, хог хаягдлыг зориулалтын цэг рүү тээвэрлэв. Энэхүү арга хэмжээ нь байгаль орчны талаарх хариуцлагыг нэмэгдүүлэх, хамтын оролцоог дэмжихэд чиглэв.



Гол усны эх хамгаалах: Гачуурт тосгоны Шар хоолойн аманд байрлах булгийн эхийг хамгаалан 62 м² талбай бүхий хашаа байршууллаа. Булгийн эхийг хамгаалснаар газрын доорх усны чанарыг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг дэмжихээс гадна орон нутгийн иргэд, ан амьтдын цэвэр, баталгаат усаар хангагдах чухал ач холбогдолтой юм.





Зорилго:

Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий Монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.

■ ИРЭЭДҮЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ДЭМЖИХ НЬ

АПУ ХК-ийн "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн стратегийн "Хүчирхэгжсэн хамт олон" зорилгын хүрээнд ирээдүйн мэргэжилтнүүдийг дэмжих зорилгоор 100 оюутныг хамруулсан "INNOV-TALENT – Инновацилаг ур чадварын тэтгэлэгт хөтөлбөр"-ийг амжилттай зохион байгууллаа.



I YE ШАТ

2025 оны 01-р сараас эхэлж, инженерчлэл, мэдээллийн технологи, шинжлэх ухаан, бизнесийн удирдлага, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй 100 оюутан шалгаруулав. Шалгарсан оюутнуудыг АПУ ХК-ийн NOVA-LMS мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудад тогтмол хамруулж мөн, төслийн илтгэл тавих сургалт, коучинг хичээлүүд орсон бөгөөд уг шатанд 40 гаруй оюутан мэргэжлийн дадлага хийсэн.



II YE ШАТ

Оюутнуудаа 10 багт хувааж төслийн тогтвортой хөгжил, байгаль орчинд ээлтэй төслийн уралдаан зохион байгуулсан бөгөөд шар айрагны шаараар гоо сайхны бүтээгдэхүүн болон кофены шаараар муурны элс үйлдвэрлэх, сургуулиудад шүд угаах цэг байгуулах, "Эмн-Өвчтөн-Эмийн санч" нарыг холбох цахим жор зэрэг сонирхолтой төслийн саналуудыг уралдуулсан юм. Тэднийг тэмцээндээ бэлтгэхэд нь TedX илтгэлийн коуч Л. Бямбасүрэн "How to Pitch" сургалт баг бүрд тусгайлан орсон. Ингээд 2025 оны 05-р сарын 14-нд "Ауруг Плэйс"-д шилдэг 3 баг шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, оролцогчид 5-7 минутын илтгэлээр төслөө танилцуулсан бөгөөд шүүгчдийн үнэлгээгээр дараагийн шатанд оролцох шилдэг багуудыг тодруулсан юм.



III YE ШАТ

2025 оны 06-р сарын 18-нд болж, шилдэг гурван багийн төслөө танилцуулах финалын илтгэлээр үргэлжилсэн. "BrainFuel Box" баг оюутнуудын шим тэжээлийн дутагдлыг арилгах зорилгоор их сургуулиудад сүүн бүтээгдэхүүн борлуулдаг автомат худалдааны машин байршуулах санаа боловсруулж, харин "Гүйдлийн хяналтын систем" баг нь ахуйн болон ажлын байрны үр ашигүй цахилгааны гүйдлийг бууруулах зорилготой төхөөрөмж зохион бүтээх төсөл танилцуулснаас "MonGuide" багийн хиймэл оюун ухаан дээр суурилсан ургамлын аппликэйшн бүтээн, тэмцээн дээр демо хувилбараа танилцуулан тэргүүн байр эзэлж, 10 сая төгрөгийн шагналын эзэн болсон билээ.

Хөтөлбөрийн хүрээнд оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг, цалинтай дадлага хийх, бодит бизнесийн төсөл дээр ажиллах боломжийг бүрдүүлснээс гадна төгсөлтийн дараа АПУ компанид ажиллах боломж олгосон нь ирээдүйн боловсон хүчнийг бэлтгэх, компанийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан нийгэмд урт хугацааны зэрэг нөлөө үзүүлэхийг зорьлоо.

"BREW THE FUTURE" ДОТООД ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР:

АПУ ХК нь хүнс, ундаа үйлдвэрлэлийн салбарт тогтвортой, чадварлаг боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх зорилгоор дотоод ажилтнуудад чиглэсэн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлээ.



Тус хөтөлбөр нь компанид 6 сар ба түүнээс дээш хугацаанд ажилласан, бүрэн дунд болон мэргэжлийн үнэмлэхтэй ажилтнуудад мэргэжлийн ур чадвараа ахиулах, нарийн мэргэжил эзэмших боломжийг олгох зорилготой. Хөтөлбөрт хамрагдсан ажилтнууд 1-3 жилийн хугацаанд ажиллангаа суралцах нөхцөлөөр хангагдаж, сургалтаа амжилттай төгссөний дараа эзэмшсэн мэргэжлээрээ үйлдвэртээ үргэлжлүүлэн ажиллах боломж бүрдэж буйгаараа онцлог юм.

Энэхүү санаачилга нь үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах мэргэжилтэн бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ажилтнуудын карьерын өсөлт, хөгжлийг дэмжиж, залуучуудад ур чадвараа ахиулах боломж олгох замаар нийгэмд урт хугацааны эерэг нөлөө үзүүлэхэд чиглэж байна.

2025 оны байдлаар АПУ ХК (7 ажилтан) үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр техникч болон мэргэжлийн үнэмлэхээр суралцаж байгаа бөгөөд охин компаниуд болох АПУ Трейдинг (6), МВС Азия Пасифик (3), СББ (4), АПУ Дэйри (2) компанийн ажилтнууд мэргэжлийн техникч болон цахилгаанчны чиглэлээр тус тус суралцаж байна.



НЭГ ЗУН=НЭГ БОЛОМЖ ХӨТӨЛБӨР

Сургалтын төлбөр хуримтлуулах хөтөлбөр амжилттай хэрэгжүүлээ.

Хөтөлбөрийн хүрээнд оюутнууд зуны амралтаараа Агуулахын туслах ажилтан, Түгээлтийн туслах ажилтан, Багцлалтын туслах ажилтан, Шил угаагч зэрэг ажлын туршлага хуримтлуулж, хариуцлага, багаар ажиллах чадвараа хөгжүүлэн сургалтын төлбөрийн тэтгэлэг болох 1-2 сая төгрөг авсан.

Тэтгэлэг олгох шалгуурт цагийн ажил ирцийн оноо дээр үндэслэн төлбөрийн тэтгэлэг олгосон.



Тогтвортой хөгжлийн цахим сургалттай боллоо

Тогтвортой хөгжлийн чиглэлээр 9 модуль бүхий сургалтыг шинээр боловсруулж, богино контент хэлбэрээр бэлтгэн, цахим сургалтын системд байршууллаа.

Уг сургалтаар суралцагч нь тогтвортой хөгжлийн суурь ойлголт, НҮБ-ын 17 зорилго болон Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтуудыг ойлгохын зэрэгцээ АПУ компанийн тогтвортой хөгжлийн стратеги, бодлого, хүлэмжийн хийн ялгарал ба уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эдгээрийг өдөр тутмын ажил, амьдралдаа хамтдаа хэрэгжүүлэх бодит дадлыг цогцоор нь эзэмшинэ.

Мөн сургалтад олон улсын компаниуд тухайн сэдвийн чиглэлээр анхаарч ажилласнаар ямар ямар ажил хэрэгжүүлсэн, үр дүнд юу болов, хэдий хэмжээний санхүүгийн хэмнэлт гарсан зэрэг практик талаас бэлдсэн юм.

Ажилтнууд уг сургалтыг үзээд, олон улсын кэйс жишээнээс суралцан, шалгалт өгснөөр онлайн сертификат авах мөн боломжтой.



APU COMPANY
Amulac Pure Unique



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ СУРГАЛТ NOVA LMS-Д ОРЛОО

Хичээлийн агуулга:

1. Тогтвортой хөгжлийн суурь ойлголтууд, кэйс жишээ
2. АПУ компанийн Тогтвортой хөгжлийн стратеги, бодлого, кэйс жишээ
3. Хүлэмжийн хий ба бидний ялгарал, кэйс жишээ
4. Хог хаягдлын ангилан ялгалт ба тойрог эдийн засаг, кэйс жишээ
5. Эрчим хүч ба дулаан, кэйс жишээ
6. Ус, кэйс жишээ
7. Хариуцлагатай хэрэглээ, кэйс жишээ
8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, кэйс жишээ
9. Бизнесийн ёс зүйн дүрэм, журам, кэйс жишээ



БАХАРХАЛТ
МОНГОЛ
Тогтвортой хөгжлийн стратеги 2030





СУРГАЛТ, ХӨГЖИЛ БА ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Бид ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхийг зорилгоо болгон ажилладаг.

Сургалтын гүйцэтгэл: 2025 онд нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг 13.1 цагт (АПУ Дэйри ХХК-ийн хувьд 13.6 цаг) хүрч, өмнөх оноос ахиц үзүүлээ. Тогтвортой хөгжлийн тухай сургалтыг шинэ ажилтнуудын хөтөлбөрт нэгтгэж, 2025 онд 193 шинэ ажилтныг хамруулсан.

Танхимын сургалт: Үйлдвэрлэлийн зургаан байршилд Дэлхийн усны өдөр, Дэлхийн хүрээлэн буй орчны өдөр, Дэлхийн хог хаягдлын эсрэг өдөр зэргийг тохиолдуулан, ажилтдад зориулсан сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг өдөрлөгт нийт 308 ажилтан танхимаар хамрагдлаа.

Тогтвортой байдал: Группийн хэмжээнд үндсэн ажилтнуудын сэлгээний хувь (turnover rate) 18.6% байна. Бид ажилтнуудын тогтвор суурьшил, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх халамжийн хөтөлбөрүүдийг шат дараатай хэрэгжүүлж байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ (ХАБЭА)

Бид "Аюулгүй ажиллагаа-Нэгдүгээрт" зарчмыг баримтлан, олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

Бодлого ба амлалт: Группийн хэмжээнд ХАБЭА-н 14 журмыг мөрдөж, Heineken-ий "Амь насаа хамгаалах 12 амлалт"-ыг хэрэгжүүлж байна.

Осол аваар: 2025 онд хөдөлмөрийн чадвар алдсан ослын давтамж 200,000 хүн/цаг тутамд 0.05 гэсэн бага үзүүлэлттэй байлаа.

Эрүүл мэндийн хөтөлбөр: Нийт 8,478 ажилтанд эрүүл мэндийн зөвлөгөө, яаралтай тусламж үзүүлсэн. Хүнсний үйлдвэрлэлийн ажилчдын зайлшгүй үзлэгт АПУ ХК 69% ажилтан, АПУ Дэйри ХХК 348 ажилтныг 100% хамруулсан бол эмэгтэйнүүдийн умайн хүзүүний хавдрын илрүүлэгт 160 ажилтныг хамруулж, шаардлагатай дэмжлэг үзүүллээ.

ОЛОН ТАЛТ БАЙДАЛ, ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА ХҮРТЭЭМЖ

Бид "Аюулгүй ажиллагаа-Нэгдүгээрт" зарчмыг баримтлан, олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог.

Бодлого ба амлалт: Группийн хэмжээнд ХАБЭА-н 14 журмыг мөрдөж, Heineken-ий "Амь насаа хамгаалах 12 амлалт"-ыг хэрэгжүүлж байна.

Осол аваар: 2025 онд хөдөлмөрийн чадвар алдсан ослын давтамж 200,000 хүн/цаг тутамд 0.05 гэсэн бага үзүүлэлттэй байлаа.

Эрүүл мэндийн хөтөлбөр: Нийт 8,478 ажилтанд эрүүл мэндийн зөвлөгөө, яаралтай тусламж үзүүлсэн. Хүнсний үйлдвэрлэлийн ажилчдын зайлшгүй үзлэгт АПУ ХК 69% ажилтан, АПУ Дэйри ХХК 348 ажилтныг 100% хамруулсан бол эмэгтэйнүүдийн умайн хүзүүний хавдрын илрүүлэгт 160 ажилтныг хамруулж, шаардлагатай дэмжлэг үзүүллээ.



"Дижитал сургалтаар ажилтны хөгжлийг хурдасгах нь"

Б.Тэмүүжин

Цахим сургалтын менежер

Би 2021 онд ажлын гараагаа эхлүүлж, одоо АПУ Группийн Хүний нөөцийн сургалтын албанд цахим сургалт хариуцан ажиллаж байна. Манай баг NOVA LMS системийг нэвтрүүлснээр сургалт, хөгжлийн үйл ажиллагааг бүрэн дижитал хэлбэрт шилжүүлж байна.

Энэхүү системээр ажилтан бүр ур чадвараа үнэлж, хөгжүүлэх, ахиц дэвшилээ хянах, өөрийн суралцах үйл явцыг удирдах боломжтой болсон. Мөн байгууллагын хэмжээнд ур чадварын нэгдсэн мэдээллийн сан бүрдэж, хүний нөөцийн хөгжлийг илүү оновчтой төлөвлөх нөхцөл бүрдэж байна.



Зорилго:

Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмнээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвшээнд.

Нийгмийн хариуцлага болон байгаль орчны тогтвортой байдлын хүрээнд АПУ ХК нь харилцагч байгууллагууддаа эрчим хүчний хэмнэлттэй хөргөгчүүдийг үе шаттайгаар нийлүүлж, хэрэглээний цахилгаан зарцуулалтыг бууруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлээ. Энэхүү санаачилга нь харилцагчдын бизнесийн тогтвортой өсөлтийг дэмжихийн зэрэгцээ нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулж байна.

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

Playtime наадмын хүрээнд хариуцлагатай хэрэглээний аян өрнүүлж, 70 гаруй хэрэглэгч UBСAВ дуудлагын жолоочийн бугуйвч дээрх QR кодыг уншуулан хөнгөлөлтийн купон ашиглан, "Гайхамшиг жолооч уусан бол жолоо барьдаггүй" аянд нэгдэв.



APU COMPANY
Absolute. Pure. Unique.



UBCAB



УДИРДЛАГ

АПУ ХК-ийн тогтвортой байдлын удирдлага

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН 5 ХАНА

ХАВСРАЛТ

ИННОВАЦ, ШИНЭЧЛЭЛ

Хэрэглэгчдийн сонголтод зориулж "Orgilun Zero" (Calamansi амттай) болон "Terej Zero" зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлээ.

Уламжлалт сүү хөөрүүлэх соёлыг орчин үеийн технологиор баяжуулсан "Их Нүүдэл" өрөмтөг сүүг зах зээлд амжилттай нэвтрүүлж, үндэсний өвийг бизнесийн инновацитай уялдуулсан юм. Мөн Creamy Milk сүүг нарийн боов, амтан, смүүти, латтенд хэрэглэхэд зохицуулан бүтээлээ.



ДЭЛХИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Монгол сүүний үнэ цэнийг дэлхийн тавцанд баталж, АПУ Дэйри компанийн PRO+ Болгар taper, PRO+ Healthy Milk, Mont-Yak Шар тос бүтээгдэхүүнүүд олон улсын "Superior Taste Award 2025", Ginger Ale бүтээгдэхүүн маань "Monde Selection GOLD 2025" шагналыг тус тус хүртлээ.



ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙН ТҮГЭЭХ

Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор UB marathon олон улсын марафонд ивээн тэтгэгчээр хамтран ажиллалаа. Үүгээр зогсохгүй АПУ компанийн хамтран ажилладаг баг тамирчдаараа дамжуулан залуусыг спортын соёлд уриалсан контент ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



ОЛОН НИЙТИЙГ СЭДЭЛЖҮҮЛЭХ, УРИАЛАХ

Энэ хүрээнд эрчим хүчний хэмнэлт, усны эохистой хэрэглээ, байгаль хамгаалад, хог хаягдлыг бууруулах зэрэг сэдвүүдээр олон нийтэд чимлэсэн мэдээлэл, нөлөөллийн контентыг тогтмол бэлтгэн түгээж, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хариуцлагатай хэрэглээ, тогтвортой дадлыг хэвшүүлэхэд уриалан ажиллаж байна.



Д.Билиг
АПУ ХК-ийн Аюулгүй байдал хариуцсан ахлах ажилтан, Achilles клубийн гар дугуйн спортын тамирчин



Зорилго:

Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөлөврөө жишиг байгууллага байна.

■ ЗАСАГЛАЛЫН БЭХЖҮҮЛЭЛТ

АПУ ХК-ийн бизнесийн гэрээ, хэлцлүүдэд тогтвортой хөгжлийн заалтуудыг тусгайлан оруулж өгсөн нь компанийн засаглалыг шинэ түвшинд гаргаж, нийлүүлэлтийн сүлжээний хариуцлагыг нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой алхам болсон юм. Эдгээр заалтуудын ерөнхий тойм, тэдгээрийн үзүүлэх зэрэг нөлөөг дараах байдлаар тодорхойлж байна.

Тогтвортой хөгжлийн заалтуудын нэгдсэн тойм

Гэрээний шинэ заалтууд нь талуудын хүлээх үүргийг гурван үндсэн чиглэлд тодорхой зааж өгсөн:

- Байгаль орчин: Байгалийн нөөцийг хэмнэх, хаягдлыг багасгах, дахин боловсруулалтыг дэмжих болон хорт бодис агуулаагүй түүхий эд ашиглах замаар байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгах үүргийг тусгасан.
- Хүний эрх ба Хөдөлмөрийн харилцаа: Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, жендэрийн тэгш байдлыг хангах, шударга цалин хөлс олгох болон хүүхдийн эрхийг дээдлэн хамгаалах зохицуулалтуудыг оруулсан.
- Бизнесийн ёс зүй: Талууд үйл ажиллагаандаа ёс зүйн стандартыг баримталж, "Нийлүүлэгчийн дүрэм"-ийг чанд мөрдөх үүрэг хүлээж байна.

Эдгээр заалтуудыг гэрээнд тусгаснаар дараах нөлөөлөл бий болно:

- Эрсдэлийн удирдлага: Нийлүүлэлтийн сүлжээнд гарч болзошгүй хүний эрхийн зөрчил, байгаль орчны хохирол болон ёс зүйн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн баталгаа болно.
- Стандартчилал: Хамтран ажиллагч түншүүд, нийлүүлэгчид бүгд ижил түвшний өндөр стандарт, хэм хэмжээг баримтлах нэгдсэн соёл төлөвшинэ.
- Ил тод байдал: Олон улсын стандартад (СТОУС) нийцсэн тайлагнал гаргахад шаардлагатай мэдээллийн үнэн зөв байдал баталгаажиж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлнэ.

Заалтуудын хэрэгжилт нь нийгэм болон бизнесийн орчинд дараах бодит нөлөөг үзүүлнэ:

- Нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлт: Нийлүүлэгчид үйл ажиллагаагаа илүү байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай хэлбэрт шилжүүлж эхэлнэ.
- Нийгмийн хариуцлага: Хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй ажлын байр нэмэгдэх зэргээр малчид, фермерүүд болон нийт ажилтнуудын амьдралын чанарт нөлөөлнө.
- Байгаль орчны хамгаалал: Үйлдвэрлэлийн бүхий л шатанд ус, эрчим хүчний хэмнэлт гарч, байгаль орчинд үзүүлэх экологийн мөр багасна.

Товчоор хэлбэл, эдгээр заалтууд нь АПУ ХК болон түүний түншүүдийн хоорондын харилцааг зөвхөн санхүүгийн ашиг сонирхлын түвшинд бус, харин хамтын үнэ цэнийг бүтээх хариуцлагатай түншлэл болгон хувиргаж байна.

■ ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

Компанийн Цалин урамшууллын бодлогод ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувыцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталж, гүйцэтгэлийг Компанийн жилийн тайланд тодорхой тусгахаар заасан.

ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог ба нэмэлт урамшуулал олгодоггүй. 2025 онд цалин, урамшууллын хэмжээнд өөрчлөлт ороогүй бөгөөд татвар, суутгал хасаагүй дүнгээр ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөгийн цалинг сар бүр олгосон.

■ НЭГДСЭН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АПУ ХК нь эрсдэлийн удирдлагыг байгууллагын соёлын салшгүй хэсэг болгон төлөвшүүлэх, компанийн үнэ цэнийг хамгаалах ба бий болгох, стратеги болон үйл ажиллагааны шийдвэр гаргалтад бодит үндэслэлтэйгээр ашиглах, ил тод бөгөөд найдвартай мэдээллийн эх үүсвэрт тулгуурлах, тасралтгүй сайжруулалт бүхий тогтвортой тогтолцоог бүрдүүлэх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна. 2025 онд тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэх, урт хугацаанд компанийн үнэ цэнийг хамгаалах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор Эрсдэлийн удирдлагын бодлогыг тогтвортой хэрэгжүүлж ажилласан.

Бизнесийн тогтвортой ажиллагааг хангах зорилгын хүрээнд 2025 онд АПУ ХК-ийн бүх үйлдвэрлэл, үйл ажиллагааны байршлуудад олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Энэхүү үнэлгээний үр дүнг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ашиглахаас гадна болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны процессуудыг сайжруулах санал санаачилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлж, бизнесийн үнэ цэнийг бэхжүүлэх, тасралтгүй хөгжлийн соёлыг төлөвшүүлэх зорилгоор ашиглаж байна.

Компанийн дотоод үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын программ хангамжийг ашиглан болзошгүй эрсдэлүүдийг бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл болон илрэх магадлалаар нь үнэлэн тодорхойлж, богино болон урт хугацаанд эрсдэлүүдийг оновчтой удирдах шийдвэр гаргалтад ашиглаж байна.

Мөн салбар болон компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх томоохон эрсдэлүүдийг тодорхойлон үнэлж, эдгээрээс ач холбогдлоороо хамгийн өндөрт эрэмбэлэгдсэн дараах дөрвөн үндсэн эрсдэлийг онцлон тодорхойллоо. Үүнд:

- | | |
|---|---|
| • Түүхий эд, бараа материалын ханган нийлүүлэлт | • Эрчим хүчний хангамж ба тогтвортой байдал |
| • Импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт | • Хэрэглээний хязгаарлалт |
| • Логистикийн үйл ажиллагаа | • Эрчим хүч, дулааны үнийн өсөлт |
| • Эдийн засгийн нөхцөл байдал | • Хөдөлмөрийн зах зээл |
| • Гадаад валютын ханшийн хөдөлгөөн | • Ажиллах хүчний тогтвортой байдал |
| • Инфляц | • Мэргэшсэн ажиллах хүчний хомсдол |
| • Хэрэглэгчийн худалдан авах чадамж | |

КОМПЛАЙНСЫН НЭГЖ

Комплайнсын нэгжийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс баталсан "Комплайнсын хяналтын заавар", "Бизнесийн ёс зүйн дүрэм" багц бодлогын "Мөнгө угаахтай тэмцэх, хориг арга хэмжээний бодлого" болон "Хориг арга хэмжээний журам"-ыг тус тус баримтлан ажиллав.

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

АПУ компанид Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2023 онд батлагдаж, 2025 онд нэмэлт орсон "Бизнесийн ёс дүрэм" багц бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд АПУ ХК болон түүний охин компаниудын бүхий л ажилтнууд үйл ажиллагаандаа ёс зүйн бодлого, дүрмийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүний эрхийн бодлого	Компанийн хөрөнгө ашиглах бодлого	Нууц мэдээллийн бодлого	Залилангийн эсрэг бодлого
Бэлэг, хандивын бодлого	Авлигаас урьдчилан сэргийлэх бодлого	Өрсөлдөөний бодлого	Олон нийтийн сүлжээ ашиглах бодлого
Мөнгө угаах, хориг арга хэмжээний бодлого	Ашиг сонирхлын зөрчлийн бодлого	Нийлүүлэгчийн дүрэм	Оюуны өмчийн бодлого
Эрх бүхий албан тушаалтны ёс зүйн дүрэм (2025.05.17)	Согтууруулах ундааны хариуцлагатай хэрэглээний бодлого	Сахилгын арга хэмжээний бодлого	

ҮРГЭЛЖ "ЁС ЗҮЙ" ӨӨДӨӨ АЯН – СУРГАЛТ

Бид өөрсдийн баримталдаг зарчмаа эрхэмлэж, ёс зүйн бодлого дүрмийн сургалтыг ажилтан бүрт явуулдаг ба 2025 онд сургалтыг Nova Learning Management System цахим сургалтын платформоор дамжуулан нийт 2,500 ажилтанд орсон байна.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ

2024 онд ашиглалтанд оруулсан бизнесийн ёс зүйн зөрчил болон аливаа зүй бус үйлдлийн талаар мэдээллийг хүлээн авах, нэрээ нууцалж мэдээлэл гаргах, гаргасан мэдээллийнхээ шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой "Шүгэл үлээх систем"-ээ үргэлжлүүлэн ашиглалаа.



Шүгэл үлээх сувагууд:

Шүгэл үлээх системээр:	Имэйлээр:	Биечлэн:
www.speakup.apu.mn	speakup@apu.mn	Шууд удирдлагадаа мэдэгдэх

Захиргаа, хүний нөөцийн газар, Хуулийн алба, Дотоод аудитын албаны ажилтнуудад мэдэгдэх

Байршил бүр дээр сонгогдсон Итгэмжлэгдсэн төлөөлөгчдээр дамжуулан мэдээлэл гаргах боломжтой.

"Байгаль орчны менежментээр тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих нь"

Б.Номинжаргал

Байгаль орчин, тогтолцоо хариуцсан мэргэжилтэн

Би байгаль орчны салбарт 11 дэх жилдээ, шингэн хүнсний үйлдвэрлэлийн салбарт 3 дахь жилдээ ажиллаж байна. Манай компани ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа байгаль орчны нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг хангах чиглэлд тасралтгүй сайжруулалт хийдэг.

Энэхүү тогтолцооны хүрээнд хууль тогтоомжийн нийцлийг хангаж, үйл ажиллагаагаа олон улсын аудитын байгууллагаар жил бүр баталгаажуулдаг. Миний хувьд байгаль орчны менежментийн тогтолцоогоор дамжуулан нөөцийг хариуцлагатай ашиглах, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихэд хувь нэмрээ оруулж байна.

МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ




Ийнхүү дээрх сувгуудаар ирсэн мэдээллүүдийг Комплайнс менежер нэгтгэн хүлээн авч, Бизнесийн ёс зүйн хороонд шилжүүлж, шийдвэрлүүлж, ТУЗ-д тайлагнаж ажилладаг. 2025 онд нийт 10 мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн байна.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНЭЭС СЭРГИЙЛЭХ

Бид аливаа худал, хууль бус үйлдлийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримталдаг бөгөөд Олон улсын LexisNexis системийн тусламжтай Компанитай гэрээлэгч хуулийн этгээд, хувь хүнийг шүүн шалгаж, хориг арга хэмжээнд орсон талтай аливаа бизнесийн холбоо тогтоохоос сэргийлэн ажилладаг.

ДОТООД АУДИТЫН БҮТЭЦ



ДОТООД АУДИТЫН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ:

Дотоод аудитын чиг үүргийг 2024 онд Үйл явц, хяналт, сайжруулалтын алба хэрэгжүүлдэг байсан бол тус алба 2025 оноос Дотоод аудит, Эрсдэлийн удирдлага, Процесс сайжруулалтын алба гэсэн 3 албанд хуваагдан хэрэгжүүлсэн.

ТУЗ-өөс томилсон Дотоод аудитын нэгжийн удирдлага өөрчлөгдөөгүй бөгөөд дотоод аудитын алба 2025 онд 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

"Техник тусалцаагаар нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх нь"

Ц.Ичинхорлоо

Үйлдвэрлэл үйл ажиллагааны ахлах менежер

Би АПУ компанид 17 дахь жилдээ ажиллаж, ажлын гараагаа чанарын мэргэжилтэн, микробиологичаар эхлүүлсэн. Энэ хугацаанд бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарын хяналтын чиглэлээр хуримтлуулсан туршлага маань өнөөдөр нийлүүлэлтийн сүлжээний нийцэл, бүтээмжийг сайжруулах ажилд чухал суурь болж байна.

Бид EBRD, ADB-ийн хамтын санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй техник тусалцааны ажлыг FAO болон Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд малчид, фермерүүдэд малын тавлаг байдал, тэжээлийн бодлого, цур амьсгалд дасан зохицох чиглэлээр маш олон сургалт зохион байгуулж, цахим сургалтын платформ болон дижитал үнэлгээний системийг нэвтрүүлсэн. Ингэснээр нийлүүлэгчдийн мэдлэг, ур чадвар сайжирч, сүүний чанар, бүтээмж, тогтвортой байдал бодитоор нэмэгдэж байна.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Олон улсын үнэлгээ: 2025 оны 2 дугаар сард АПУ Дэйри-ийн тогтвортой хөгжлийн санаачилга нь Тогтвортой банк санхүүгийн сүлжээ (SBFN)-ийн вэб сайтад дэлхийн шилдэг кэйс жишээнүүдийн нэгээр нийлэгдлээ.

[APU Dairy's Role in Strengthening Mongolia's Dairy Sector: EBRD and ADB Support | SBFN](#)

- Монголын уламжлалт нэрмэл архины өв соёл, орчин үеийн үйлдвэрлэлийн онцлогийг сонирхсон АНУ-ын сэтгүүлчид өөрсдийн хүслээр АПУ компанид зочлон, компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанар, соёлын өвтэй уялдсан үйлдвэрлэлийн арга барилтай танилцаж, Монголын архины салбарын онцлогийг олон улсад сурталчилсан нийтлэл бэлтгэлээ.

[Mongolian vodka: A modern industry in an ancient world - Drinks International - The global choice for drinks buyers](#)

- ТоС холбооны дэргэд "Бизнес мэргэжлийн зөвлөл"-ийг АПУ компанийн Тогтвортой байдлын менежер Э.Мөнхтуул санаачлан байгуулж, ажиллаж байна. Тус зөвлөл нь бизнесийн байгууллагын гишүүдийн тогтвортой хөгжлийн чиглэл дэх үйл ажиллагааг уялдуулах, хамтын дуу хоолойг нэгтгэн төр, бодлого тодорхойлогчдод хүргэх, мөн хувийн хэвшлийн оролцоог бодлогын түвшинд нэмэгдүүлэх зорилготой.
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк-ийн зохион байгуулсан "Тэсвэртэй хүнсний тогтолцоог бий болгох нь: Сорилт ба шийдлүүд" сэдэвт хэлэлцүүлэгт оролцов.
- Санхүү эдийн засгийн сургуулиас зохион байгуулсан Компанийн засаглалын өнөөгийн чиг хандлага: Боломж ба сорилт хэлэлцүүлэгт оролцов.
- ТоС холбооны цахим товхимлоор дамжуулан сар бүр 3700 гаруй уншигчдад Монгол, Англи хэл дээр үйл ажиллагааны мэдээллээ түгээж байна.

Есдүгээр сар - <https://www.toc.mn/publication/september-newsletter-msfa>

Аравдугаар сар - <https://www.toc.mn/publication/october-newsletter-msfa>

Арваннэгдүгээр сар - <https://www.toc.mn/publication/november-newsletter-msfa>

Арванхоёрдугаар сар - <https://www.toc.mn/publication/december-newsletter>

"ШИЛДЭГ БОНЗ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА 2025"

Монголын Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) Холбоо, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооноос жил бүр уламжлал болгон тогтвортой ногоон, хариуцлагатай бизнесийн шилдгүүдийг тодруулдаг шалгаруулалтаар АПУ ХК "Шилдэг Бонз хэрэгжүүлэгч байгууллага 2025" гэсэн нэр хүндтэй шагналыг анх удаа хүртлээ.

Энэхүү үнэлгээ нь тухайн байгууллагын тогтвортой байдлын удирдлагын систем, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо, хэрэгжилтийн үр дүнг олон талт үнэлгээгээр дүгнэдэг шалгаруулалт юм.



ХАВСРАЛТ

Монголын Хөрөнгийн Биржийн БоНЗ-ын үйл ажиллагааны тайлан

"Техникийн инновацаар ялгарлыг бууруулах нь"

Д.Бат-Орших

Авто ашиглалтын инженер

Би АПУ компанид 16 дахь жилдээ ажиллаж, тээврийн хэрэгслийн аюулгүй, найдвартай, үр ашигтай ашиглалтыг хангах чиглэлээр ажиллаж байна. Миний зорилго бол автомашины техникийн бэлэн байдлыг хангаж, эсвэр үйлчилгээний чанар, үр ашгийг тасралтгүй сайжруулах юм.

2025 онд 24 автомашинд "Eco Mine System" төхөөрөмж суурилуулж, гүйцэтгэлийн хяналт, сайжруулалтын ажлыг хэрэгжүүлсэн. Суурилуулснаас хойш 3 сарын дараах хэмжилтээр тартагжилт дунджаар 50%-иар буурсан үзүүлэлт гарсан. Энэ нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ялгарлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулж байна.

**“Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын
Хавсралт 1.**

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь “Монголын хөрөнгийн бирж” ХХК-д бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Огноо (он, сар, өдөр):	2025.04.27
Үнэт цаас гаргагчийн нэр:	АПУ ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ символ):	APU, 90
Салбарын ангилал:	Шингэн хүнс
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	АПУ ХК, М-Би-Си Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК, АПУ Дэйри ХХК, АПУ Трейдинг ХХК
Тайлангийн хамрах хугацаа:	2025/01/01 - 2025/12/31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих и-мэйл хаяг, утас:	Э.Мөнхтуул Тогтвортой байдлын менежер munkhtuul.e@apu.mn, 99087876
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Ц.Эрдэнэбилэг Гүйцэтгэх захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

	Бүлэг	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (2024)	Үзүүлэлт (2025)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Холбоос
		Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд						
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм	Тийм		АПУ ХК нь “Дэлхийд танигдах эрхэм Монгол хүний оюун чадвар, ур ухаан, шинэчлэл, тогтвортой хөгжлийн ундарга байя” гэсэн алсын хараагаа хэрэгжүүлэх хүрээнд Тогтвортой хөгжлийн стратеги батлан, байгууллагын бодлого, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэн ажиллаж байна.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм	Тийм		ТУЗ-ийн 2024.07.23-ны өдрийн хурлаар “Бахархалт Монгол” тогтвортой хөгжлийн 2030 стратегийг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжлийн 2024, 2025 оны жилийн тайлангаас уншина уу.	GRI 103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	Үгүй		Тогтвортой хөгжлийн албан ёсны хороо байхгүй хэдий ч “Бахархалт Монгол” тогтвортой хөгжлийн 2030 стратегийн 5 баганын хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг хариуцах С түвшний захирлууд томилогдон ажиллаж байна. Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжлийн 2024, 2025 оны жилийн тайлангаас уншина уу.	GRI 103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	Үгүй		ТУЗ-ийн түвшинд тусгайлан томилогдсон гишүүн байхгүй боловч улирал бүр ТУЗ-д тайлагнадаг.	GRI 102
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм		Гүйцэтгэх захирал	GRI 102
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм		Тогтвортой байдлын менежер болон Тогтвортой байдлын ажилтан бүтэн цагаар ажилладаг.	GRI 102
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	Тийм	Тийм		ТУЗ-д улирал бүр тогтмол тайлагнадаг.	GRI 102
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм	Тийм		ТУЗ-р батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам Групп компанийн хэмжээнд хэрэгждэг бөгөөд журамд тусгагдсан эрсдэлийн үнэлгээний ерөнхий матрицыг ашиглан бүх төрлийн эрсдэл, боломж, түүн дотроо эдийн засаг, байгаль орчин, нийгмийн орчноос ирэх эрсдэл болон боломжуудыг үнэлж ажилладаг.	SASB
MS4.1		Чадавч бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	-	-	цаг	Тогтвортой хөгжлийн тухай сургалт нь Шинэ ажилтнуудын сургалтын агуулгад орсон байдаг бөгөөд 2025 онд нийтдээ 12 удаа зохион байгуулагдсан. Нэг удаагийн сургалт нь ажлын 8 цаг үргэлжлэх ба 2025 онд Эмэгтэй 76 Эрэгтэй 117 нийт 193 шинэ ажилтан хамрагдсан байна. Бид Тогтвортой хөгжлийн сургалтыг цахимаар бүх ажилтанд нээлттэй бэлтгэн тавьсан бөгөөд 2026 оноос энэ дата тодорхой гарах боломжтой байна.	GRI 102

MS4.2	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм	Тийм		Дотоод аудитын нэгжийн удирдлагыг ТУЗ-өөс томилсон бөгөөд тус албан тушаалтан нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд тайлагнан ажилладаг. Дотоод аудиторын ажлын чиглэлд үйл ажиллагааны аудит багтдаг бөгөөд компанийн хэмжээнд хэрэгжих буй бүх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр ашгийг үнэлдэг. Мөн гүйцэтгэлийн аудитаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор удирдлагын тогтоосон хэмжүүрийг хангаж байгаа эсэхийг үнэлдэг тул компанийн урт хугацааны зорилготой уялдсан бүхий л үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгах нь аудитын чиг үүрэгт хамаардаг.	GRI 102, SDG 12
MS4.3		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	Тийм		2022 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж, олон нийтэд нээлттэй тайлагнаж байна. https://www.apu.mn/sustainable-development?lang=	GRI 102, SDG 12
MS5.1			Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?	Үгүй	Үгүй		COSO ERM, ISO 31000, IEC 31010 стандартын дагуу эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд PESTLE, 5 Forces зэрэг макро, микро гадаад орчны нөлөөллийг үнэлэх, нөгөөтэйгүүр дотоод орчноо үнэлэх замаар тогтвортой хөгжлийн стандартад суурилан Байгаль орчин, Нийгэм, Засаглалын түвшинд эрсдэлийг үнэлж, тогтвортой хөгжлийн тайланд эрсдэлийн үйл ажиллагааг тусгаж тайлагнадаг. 2025 оноос эхлэн ISSB S1/2 стандартын дагуу дотооддоо туршиж үзлээ.	GRI 102, SDG 12
MS5.2			Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	Тийм	Тийм		Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо 2025 онд тус холбооны дэргэд Бизнес мэргэжлийн зөвлөлийн санаачлан байгуулж, даргаар ажиллаж байна.
Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	MNT 7,257,317,078.80	MNT 8,626,287,806	Mega Втц '000	Эрчим хүчний гол эх үүсвэрүүд нь төвийн эрчим хүчний систем, газ, болон хатуу түлш /нүүрс/ байна. Задаргааг доорх мэдээллүүдээс харна уу.	GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Цахилгааны нийт хэрэглээ- 25,076,642 Хэмнэлт- 103.085	Цахилгааны нийт хэрэглээ- 24,145,745 Хэмнэлтийн хэмжээ- 251.828	Mega Втц '000	2025 онд төв АПУ сайтын хэмжээнд гэрэлтүүлгүүдийг LED гэрэлтүүлгээр сольж 10 кВт-ын нарны систем суурилуулан, хийн компрессорын даралтыг бууруулж тохиргоо хийж, өвлийн улиралд гадны хүйтний энергийг ашиглаж хэмнэлт үүсгэсэн. Автомат агуулах дээр өндөр чадлын хуучин гэрэлтүүлгүүдийг бага чадлын, өндөр үр ашигтай LED гэрлээр сольж шинэчилснээр байна. Цахилгаан Эрчим Хүч хэмнэлтэй тоног төхөөрөмж ашиглахыг мөрдлөг болгон ажиллаж байна. +А led гэрэлтүүлэг сонгож авч мөн хийн компрессороос ялгарах халуун агаарыг шаардлагатай талбайг халаах /Савлах хэсэг/ шийдэл болгосон. Шаардлагагүй шат хонгил хэсгийн гэрэлтүүлгийг халж 1850кВт-ц хэмнэлт үүсгэсэн ба мэдрэгчтэй гэрэлтүүлгээр сольж байна. Ингэснээр нийт 251.828 mega Втц хэмнэсэн байна	GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Зарцуулалт 59,995.36, Хэмнэлт 3487.3	Зарцуулалт 63,528.85 Хэмнэлт 3304	BTU & % Гкал	2025 онд АПУ группийн хэмжээнд 3304 Гдж дулааны эрчим хүч хэмнэсэн ба мөнгөн дүнгээр 30.7 сая/₮ төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.	GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	20,095 тн	19,551 тн	Литр/кг & %, ГЖоуль, Tonne	АПУ группийн Зүүнхараа дахь үйлдвэр болох СББ ХХК нь өөрийн дотоод хэрэглээний дулааны эрчим хүчээ өөрсдөө үйлдвэрлэж технологийн уур болон халаалт, хэрэгцээний халуун усаа хангаж ажилладаг / Технологийн 2 уурын зуух нь 99 хувийн шүүлтийн үр ашиг бүхий фильтрийн системээр тоноглогдсон усан халаалтын 3 зуухтай үйл ажиллагаа явуулж байна /	GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	99.99	99.99	%	Зүүнхараагийн үйлдвэр дээр нүүрснээс эрчим хүч гаргаж авч ашигладаг ба Төв АПУ үйлдвэр дээр 10 кВт нарны систем суурилуулан ашиглаж байна. Эдгээрээс бусдад төвийн эрчим хүчийг ашиглаж байна.	SFRD
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0.01	0.01	%	2024 оноос туршилтын байдлаар 10кВт-ын нарны систем суурилуулан пивоны шил савны хэсгийг гэрэлтүүлэгт ашиглаж байна.	GRI 302, SDG 7
E2.1		3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	404,695.41	-	CO2e/тонн	2024 онд АПУ ХК нь анх удаа компанийн хэмжээнд Хүлэмжийн хийн (ХХЯ) тооллогыг хийж, Score 1, Score 2 болон Score 3 ялгарлыг тодорхойлсон бөгөөд уг тооллогыг олон улсын стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэж, гадны баталгаажуулалтад хамруулсан нь компанийн уур амьсгалын нөлөөллийг системтэйгээр ойлгох суурь болсон. 2025 оны тайлант хугацаанд ХХЯ-ийн тооллогыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд 2024 онд ашигласан аргачлал, хүрээ, хандлагын дагуу үргэлжлүүлэн тооцооллыг хийж, тусад нь олон нийтэд ил тод мэдээлэхээр төлөвлөж байна. Мөн ХХЯ-ийн мэдээллийг сайжруулах, автоматжуулах, дата чанарыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод систем, процессуудыг бэхжүүлэх ажлуудыг хэрэгжүүлж байна.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.

E2.2	Хүлэмжийн хийн ялгарал	3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	-	4,370 tCO ₂ e	CO ₂ e/тонн	2008–2012 онд байгууллагын тээврийн хэрэгслийн дундаж насжилт 15 жил байсан бол, 2019–2024 онд үе шаттайгаар нийт хөдлөх бүрэлдэхүүний 45%-ийг парк шинэчлэлт хийж, дундаж насжилтыг 8 жил болгон бууруулсан. Үүний үр дүнд түлшний зарцуулалт багасч, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах суурь нөхцөл бүрдсэн. 2024 оны байдлаар 2 ш BYD T3 цахилгаан автомашиныг түгээлтэд, 47 цахилгаан сэрээт ачигчыг агуулахад ашиглаж байна. Цаашид парк шинэчлэлт хийх замаар хүлэмжийн хийн ялгарлыг улам бууруулах зорилт тавин ажиллаж байна. 2025 онд парк шинэчлэлт хийж, нийт 33 автомашиныг 0 км гүйлттэй шинэ автомашинаар сольсноор тээврийн хэрэгслийн ашиглалтын үр ашиг сайжирсан. 10+ жилийн насжилттай 23 автомашинд утаа бууруулах Eco Mine систем суурилуулснаар хорт утааны агууламжийг дундажаар 50%-иар бууруулсан үзүүлэлттэй ажилласан. 2026 онд нэмэлт 23 автомашиныг шинэчлэхээр буюу парк шинэчлэлт 100% хийхээр төлөвлөсөн нь цаашдын шатахуун болон ялгарлын хэмнэлтэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Тооцооллын тайлбар: 1371 тонн түлшний дундаж нягт (0.84 кг/л) ашиглан литрт шилжүүлбэл: 1,371,000 кг÷0.84 кг/л=1,632,143 литр болно. 1 литр дизель түлшнээс дундажаар 2.68 кг CO₂ ялгардаг гэж үзвэл: 1,632,143 л×2.68 кг/л=4,374,143 кг буюу 4,374 тонн CO₂e гэж тооцсон.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	1500 хайлаас мод	1300 мод	ширхэг	Бид жил бүр хамт олноороо мод тарьдаг уламжлалтай бөгөөд 2025 оны хувьд УБ хотын Налайх дүүрэг "Торхи Тэрэлжийн" тусгай хамгаалттай газар 300 улиас мод, БЗД "Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн" 700 хайлаас мод, СХД "Инчон мөрөөдлийн төгөл" буюу хуучин хогийн цэг байсан байршилд 300 нарс мод, нийт 1300 мод тарилаа.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	Үгүй		Компанийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бие даасан журам байхгүй боловч ТУЗ-н тогтоолоор батлагдсан "Бизнесийн ёс зүйн дүрэм"-н "Нийлүүлэгчийн дүрэм"-д тусгагдсан байдаг. Нийлүүлэгчийн дүрмийн 4 гол зарчмын нэг нь "Дэлхийд нөлөөлөх нөлөөллийг багасгах" бөгөөд энэ зарчмын агуулгад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах хүрээнд баримтлах бодлогыг тодорхойлсон. ХАБЗАБО-ны албаны хариуцдаг ISO14001-д холбогдох журмууд уялдаатай. Мөн Хямралын удирдлагын гарын авлага болон Тусгайлсан 4 чиглэлд Бизнесийн тасалдалгүй ажиллагааны төлөвлөгөөтэй бөгөөд үүний нэг нь Байгалийн гамшиг болон үйлдвэрийн осол, хүн малын гоц халдварт өвчний үед хэрэгжүүлэх төлөвлөгөө байдаг.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	Үгүй		Улирал бүр PESTLE, 5 forces, SWOT шинжилгээг хийж эрсдэлийг тодорхойлж, үнэлдэг бөгөөд тус шинжилгээнд уур амьсгалын өөрчлөлтийн ерөнхий трендийг судалж, Монгол улсад нөлөөлөх нөлөөлөл болон цаашлаад компанийн зорилгод учрах эрсдэл болон компанийн үйл ажиллагааны үр дүнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт учруулж болох эрсдэлийг үнэлж TOP эрсдэлийн тайланд тусгаж, ТУЗ-д танилцуулдаг. 2025 онд хэрэгжүүлсэн IFRS S1/S2 төслийн хүрээнд уур амьсгалын эрсдэл, боломжийг дотооддоо тодорхойлсон.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Үгүй	Үгүй	Төгсөг	2025 онд байхгүй	GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	114,539,656.00	0.00	Төгсөг	2025 онд байхгүй	GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй	Үгүй		Байгалийн гамшигаас үүдэлтэй эрсдэл нь ихэвчлэн хүлээн зөвшөөрөх эрсдэлээр бүртгэгддэгч, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан түүхий эд материалын нийлүүлэлт тасалдах, хил гааль хаах гэх мэтээр материалын үнэ өсөх эрсдэлтэй байвал худалдан авалтын төлөвлөгөөг оновчлох замаар урьдчилан захиалах байдлаар ажиллаж байна. Мөн борлуулалтын үйл ажиллагаа удаашрах тохиолдлууд байдаг ч агуулахын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх замаар мөн шийдвэрлэдэг. Тухайлсан албадад тодорхойлсон эрсдэлээ хариуцуулж, эрсдэлийг бууруулах тал дээр арга хэмжээ авч ажилладаг. Үүнээс гадна жилд 2 удаа 1:1 уулзалтуудыг хийж, тодорхойлсон эрсдэл дээр зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах тал дээр төлөвлөгөө гарган хамтран ажиллаж байна.	GRI, SASB, World Economic Forum

E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	924,107	847,468	м3/л	2025 оны группийн хэмжээнд зарцуулсан цэвэр усны хэмжээ	GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	17,658	18,663	м3/л	Ус ундаа болон "Шар айрагны үйлдвэр-2"-ын хаягдал усыг тус тус дахин ашиглаж байна. 2025 онд өмнөх онтой харьцуулахад усыг эргүүлэн дахин ашигласан 18,663 м3 ус буюу 119.6 сая/т хэмнэлт гаргасан.	GRI 303, SDG 6
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	1.9	2.2	%	Нийт усны хэмжээнд дахин ашигласан усны хэмжээг харьцуулсан хувь.	GRI 303, SDG 6
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	-	-	м3/л	Бид 2024 оноос хаягдал бохир ус цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд 2026 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	150,538.87	147,860.31	тонн	2025 онд нийт 147,860.31 тонн хог хаягдал үүссэнээс 74,408.27 тонн буюу 50.3 хувийг дахин ашиглалт болон дахин боловсруулалтад хамруулсан байна. Дахин ашиглалтын дийлэнх хувийг үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох хүнсний хаягдлыг дахин ашигласан байдал бүрдүүлж байна. Цаашид ландфиллд хүргэгдэх хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд DDGS (Distillers Dried Grains with Solubles) малын тэжээлийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнийг бүрэн ашиглах, нэмүү өртөг шингээх, хог хаягдлыг бууруулахад чиглэсэн чухал алхам болж байна.	GRI 306, SDG 12
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	74.65%	50.16%	%	Дахин ашигласан: Хатуу хог хаягдал: 1787.11 тн Хүнсний хаягдал: 72369.76 тн Дахин боловсруулсан (хатуу хог хаягдал): 250.64 тн 2025 онд хатуу хог хаягдлын 17.7%-ийг дахин ашиглаж, 2.5%-ийг дахин боловсруулсан (нийт 20.1% эргэлтэд оруулсан) байна.	GRI 306, SDG 12
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	9.36	8.67	тонн	Аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй Түмэн эгшиг ХХК, Элемент медикал ХХК компаниудтай хамтардаг бөгөөд 2025 оноос эхлэн Электрокем компанид хаягдал аккумулятор нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	GRI 306, SDG 12
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	20	20	%	Үйлдвэрийн бүсэд ногоон байгууламж багатай, оффис нэгж хэсгийн хамрах ногоон байгууламжийг жил бүр засаж сайжруулж, зүлэгжилт, ландшафтын ажлууд хийгддэг	GRI 304, SDG 15
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Үгүй	Үгүй	Төрөл зүйлийн тоо	Суурьшлын бүсэд байдаг тул энэ төрлийн хамгаалах ажил хийж хэрэгжүүлээгүй.	GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Үгүй	Үгүй	%	Суурьшлын бүсэд байдаг тул энэ төрлийн хамгаалах ажил хийж хэрэгжүүлээгүй.	SFRD, IFC Performance Standard 6
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд								
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	20.6	18.6	%	Группийн хэмжээнд нийт хүний нөөцийн эргэц 18.6% тай байна	GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	-	-	Тоо	2025 онд шинээр орон тоо нэмээгүй болно.	GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	12.3	13.1	цаг	АПУ ХК, АПУ Трейдинг, СББ Трейд, МВСАР, СББ компанийн 2025 онд зохион байгуулагдсан сургалтуудын нэг хүнд ногдох сургалтын дундаж хүн цаг 13.1 бол АПУ Дэйри ХХК-ийх 13.6 цаг байна.	GRI 401, SDG 8

S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЗА)	ХАБЗА-н бодлого	ХАБЗА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" гэх мэт группийн хэмжээнд нийтдээ 14 журмыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ Heineken-ий ХАБЗА-н "Амь насаа хамгаалах 12 амлалт"-ыг мөрдлөг болгон ажилладаг. https://www.theheinekencompany.com/sites/heineken-corp/files/heineken-corp/sustainability-and-responsibility/our-progress/our-policies/heineken-life-saving-commitments.pdf	GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	-	0.05	%	2025 онд групп компанийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан ослын давтамж 200,000 хүн цаг тутамд 0.05 гэсэн үзүүлэлттэй байна. Аюулгүй ажиллагааны мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор "Сэрээт ачигчийн ур чадварын уралдаан", "Аюулыг ангуучлая" сарын аян, ХАБЗА-н бооцоот тэмцээн, видео рийл уралдаануудыг зохион байгуулсан.	GRI 403, SDG 3
S2.3		ХАБЗА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЗА сургалтын цаг	6.3 /Танхимын сургалт/	9.2	цаг	2025 онд Үйлдвэрлэл үйл ажиллагааны газарт ХАБЗАБО-ны чиглэлээр нийт 9.2 хүн/цагийн сургалтыг зохион байгуулсан байна.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	9348	8478	хүн	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд 8478 хүнд /ханиад томуу, артерийн даралт ихсэх өвчин, анхны тусламж, яаралтай тусламж, дуудлага бусад / зөвлөгөө өгч эрүүл мэндийн тусламж үзүүлэв. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хувьд Хүнсний үйлдвэрийн ажилчдын зайлшгүй шинжилгээнд АПУ ХК 2 удаа нийт 696 ажилтан, АПУ Дэйри ХХК 2 удаа 348 ажилтан хамруулж 100% гүйцэтгэлтэй хамруулав. Мөн ХУЭМТ –тэй хамтран Эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хааврын шинжилгээнд 160 ажилтан хамруулж өөрчлөлттэй гарсан 7 хүнийг дараагийн шатны эмнэлэг рүү илгээв. Анхны болон яаралтай тусламжийн хувьд 129 удаагийн давтагдсан дуудлага хүлээн авч, 12 ажилтанд яаралтай тусламж үзүүллээ.	GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		Хөдөлмөрийн дотоод журмын 18-р бүлэг. Хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай заасан байдаг.	GRI 405, SDG 5
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		АПУ ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан Бизнесийн ёс зүйн дүрмийн нэг бүрдэл болох "Хүний эрхийн бодлого"-д багтсан хүний эрхийн стандартуудын нэг нь "дарамт үзүүлэхгүй болон хүчирхийлэхгүй байх" стандарт байдаг. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын 19-р бүлэг. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид байх тухай заасан байдаг.	GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		АПУ ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан Бизнесийн ёс зүйн дүрмийн нэг бүрдэл болох "Хүний эрхийн бодлого"-д багтсан хүний эрхийн стандартуудын нэг нь "үл ялгаварлах" стандарт байдаг. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын 17-р бүлэг. Олон талт ялгаатай байдлыг хүндлэх тухай, 18-р бүлэг. Хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай тус тус заасан байдаг.	GRI 103, SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эрэгтэй 60.9% Эмэгтэй 39.1%	Эрэгтэй 62.9% Эмэгтэй 37.1%	%		GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 89% Эмэгтэй 11%	Эрэгтэй 89 % Эмэгтэй 11%	%		GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 71.4% Эмэгтэй 28.6%	Эрэгтэй 71.4% Эмэгтэй 28.6%	%		GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 61.2% Эмэгтэй 38.8%	Эрэгтэй 59.9% Эмэгтэй 40.1%	%		GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	-3.9%	-2.60%	харьцаа	Эрэгтэй ажилтнуудын цалинг эмэгтэй ажилтнуудынхтай нийтэд нь харьцуулбал 2.6-аар бага, энэ нь ажлын байрны төрөл, онцлогоос шалтгаалж байна.	GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		Хөдөлмөрийн дотоод журмын 17-р бүлэг, Олон талт ялгаатай байдлыг хүндлэх тухай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай заасан байдаг.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	1.6	2.54%	%	АПУ ХК-1.34%, АПУ Трэйдинг-2.39% СББ Трэйд-2.54%, МБС-1.33%, АПУ Дэйри-1.62%, СББ - 7.55%	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм	Тийм		АПУ компанийн 296 ажлын байранд үнэлгээ хийгдэж, тэр дотроос хурдан хугацаанд тохируулга хийх боломжтой 10 ажлын байрыг сонгон авч, ажлын байрны тохируулгуудыг шат дараатай хийж бэлэн болсон ажлын байрыг нээлттэй ажлын байрны зар болон иргэний нийгмийн ажилтнуудад мэдээлэл түгээж сонгон шалгаруулалтыг хийж байна.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	-	-	Төрөг	Зөрчил торгууль аваагүй.	SDG 10

S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм	Тийм		"Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого" https://www.apu.mn/investors-rules?lang=	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Тийм	Тийм		Группийн хэмжээнд нэгдсэн бодлого одоогоор байхгүй ч АПУ Дэйри ХХК-ийн үйл ажиллагаанд "Байгаль орчин, нийгмийн нөлөөлөх байдлын түргэвчилсэн үнэлгээ хийх журам" болон "Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх журам"-ыг 2024 онд батлан, хэрэгжүүлж байна.	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	Тийм		"Харилцагч, хэрэглэгчийн санал гомдол шийдвэрлэх журам" нь бүтээгдэхүүн үйл ажиллагаатай холбоотой харилцагч хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэхэд оршино.	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	Тийм		Бид компанийнхаа www.apu.mn вебсайтаар дамжуулж аливаа мэдээ мэдээллийг түгээдэг бол манай бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгч, харилцагч нарын санал хүсэлт, гомдол мэдээллийг 70071111 утсаар авч, Харилцагчийн удирдлага, хамтын ажиллагааны албатай холбогдож шийдвэрлүүлдэг. Ес зүйн зөрчил, аливаа зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг www.apu.mn вебсайтын "Шүгэл үлээх" цэсэнд хандаж мэдэгдэж шийдвэрлүүлдэг. Бусад өргөдөл, гомдлыг бичиг хэргийн ажилтанд хандан шийдвэрлүүлэх боломжтой.	IFC Performance Standards
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100	100	%	Тухай бүрт нь шийдвэрлэн ажилладаг.	GRI 413, SDG 8
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орногод эзлэх хувь	-	-	%	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлуудыг Үйл ажиллагааны жилийн тайлан болон Тогтвортой хөгжлийн жилийн тайланд тусгасан бөгөөд АПУ ХК нь залуус, иргэдийн эрүүл мэнд, чөлөөт цагийг дэмжих зорилгоор спорт, соёлын үйл ажиллагааг тогтмол ивээн тэтгэн ажиллаж байна. Дэлгэрэнгүйг 2025 оны Үйл ажиллагааны жилийн тайлангаас харна уу.	GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		2019 оны шинэчлэсэн "Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын журам" гэж байдаг, уг журмын 6.1 заалтад Компани нь зөвхөн бизнесийн ёс зүйн зарчим бүхий, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг, хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэй, санхүүгийн чадаахи бүхий аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллана гэж заасан байдаг.	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	30	38.5	%	Нийт худалдан авалтын үнийн дүнгийн 38.5% орчим хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгч нараас худалдаж авч байна.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	11	11	%	Үйл ажиллагаандаа ISO стандарт хэрэгжүүлсэн 60 орчим ханган нийлүүлэгч байдгаас ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлсэн нийлүүлэгчдийн тоо 22 байна.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд								
G1.1	Авлигал болон ёс зүй	Авлигын эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2023/04/3-%D0%90%D0%B2%D0%B8%D0%B8%D0%B3%D1%8B%D0%8D-%D0%B1%D0%8E%D0%B4%D0%B8%D0%8E%D0%B3%D0%8E.pdf	GRI 205, SDG 16
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33	33	%	Компанийн тухай хуудийн 75.4-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлагыг хангаж байна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	Тийм		Компанийн дүрэм болон Компанийн засаглалын дүрэм, журмуудаар хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалдаг. https://www.apu.mn/investors-rules?lang=	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/investors-rules?lang=	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2024/01/23_19a_Compliance-guidelines_mon.pdf	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм	Тийм		Бизнесийн ёс зүйн дүрмийн Шүгэл үлээх бодлого, Ашиг сонирхлын зөрчлийн бодлого, Мөнгө угаахтай тэмцэх болон хориг арга хэмжээний бодлого, Хориг арга хэмжээний журмаар зохицуулдаг. 2025 онд Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх бодлогыг шинээр баталсан. https://admin.apu.mn/wp-content/uploads/2026/01/25_17a_COI-transaction-policy_mon.pdf	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16

Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)							
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис /пестицид/	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	N/A	N/A		GRI 403, SDG 12
A2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	N/A	N/A	%	SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.03	0.1	%	GRI 416, SDG 12
MA1	Боловсруул ах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм	Тийм		GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	34	30	%	SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлсэн байдал	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	0.8	0.1	%	GRI 417, SDG 12

APU COMPANY
Absolute. Pure. Unique.



ҮРГЭЛЖ
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
ӨӨДӨӨ

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ
Улаанбаатар хот – 17040, Чингисийн өргөн чөлөө – 14
Утас: +976 – 76002220, +976 – 11 – 343063
www.apu.mn